



An illustration featuring a central magnifying glass with a silver handle and frame. Inside the lens is a cartoon businessman with brown hair, wearing a dark blue suit, white shirt, and dark tie, gesturing with his right hand. Surrounding the magnifying glass are 15 other cartoon characters representing various professions: a musician with a guitar, a construction worker in overalls, a doctor with a stethoscope, a man in a red jacket, a police officer, a woman in a blue dress, a woman with a hairbrush, a man with a megaphone, a chef, a woman with a backpack, a man with a folder, a man with a backpack, a man with a backpack, a woman with a red bag, and a man with a briefcase. The background is plain white.

2024 OH



ӨМНӨХ ҮГ

Нийгмийн даатгалын байгууллагын соёлыг төлөвшүүлэх, менежментийн чадавхийг бэхжүүлэх, иргэдийг эрсдлээс хамгаалах, удирдлага, хяналтын тогтолцоог үр ашигтай, оновчтой зохион байгуулах, нийгмийн даатгалын үйлчилгээний чанартай, хүртээмжтэй, шуурхай, нээлттэй, ил тод байдлыг хангах, улмаар хүний хөгжлийг хангах зорилгоор олон улсын MNS ISO 9001:2016 стандартад нийцсэн чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх ажлыг манай байгууллага 2016 оноос эхлэн үе шаттайгаар, холбогдох стандартаар тогтоосон шаардлагын дагуу нэвтрүүлж эхэлсэн юм. Нийгмийн даатгалын ерөнхий газар, Дорнод аймаг болон Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын газар Чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлсэн бөгөөд манай байгууллага салбарынхаа энэхүү менежментийн тогтолцоог түүчээлэн үргэлжлүүлэхийн сацуу Орхон аймгийн төрийн үйлчилгээний чанарыг манлайлан сайжруулж, иргэдэд үзүүлж буй үйлчилгээнийхээ бүхий л үйл явцыг баталгаажуулан, даатгуулагчдын сэтгэл ханамжийн түвшинг нэмэгдүүлэхээр зорилт тавин ажиллалаа.

Бид байгууллагынхаа эрхэм зорилго, хэтийн зорилго, эрхэмлэх үнэ цэнэ, чанарын бодлого, чанарын зорилтыг тодорхойлж, шилдэг мэргэшсэн, үнэнч ёс зүйтэй, хамтын ажиллагааг дэмжигч, эелдэг тусч, эрч хүчтэй, бүтээлч санаачлагатай хамт олон байхаа илэрхийлж баримтжуулав.

Манай байгууллагаас үйл ажиллагаандаа олон улсын MNS ISO 9001:2016 стандартад нийцсэн чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх стратегийн ач холбогдол бүхий шийдвэрийг 2016 онд албан ёсоор зарлан олон нийтэд тунхагласнаар нийгмийн даатгалын үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, чанартай үйлчилгээг даатгуулагчдад хүргэн тэдний сэтгэл ханамжийг дээшлүүлэхийн төлөөх тасралтгүй сайжруулалтын ухамсарт хандлага нийгмийн даатгалын ажилтнуудын харилцааны болон үйлчилгээний соёл, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх талаар хүчин чармайлт гаргахаа нотолсон билээ.



Өнгөрсөн хугацаанд бид чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлэх бэлтгэл ажлын хүрээнд Чанарын удирдлагын хороо байгуулан, тусгай удирдамж батлан төлөвлөгөөний дагуу ажиллаж ажлын байрны зураг авалт хийн, ажилтнууддаа стандартын зорилго, ач холбогдол, шаардлагуудын талаарх мэдлэг ойлголтыг олгох сургалтуудыг зохион байгуулж, Чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлсэн төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагын туршлагаас суралцав.

Чанарын удирдлагын тогтолцооны үндсэн суурь нь болох байгууллагынхаа үйл ажиллагааныхаа процессыг тодорхойлон томъёолох ажлыг Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын бүтцийн нэгж, байцаагч, албан хаагч бүрийн ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан чиг үүрэг бүрээр зохион байгуулснаар нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны үндсэн болон туслах процессуудыг тодруулан урсгалын диаграммаар баримтжуулж, тэдгээрийн орц, гарцуудын шаардлагуудыг Яст мэлхийн шинжилгээгээр шинжлэн тодорхойллоо.

Чанарын менежментийн тогтолцоонд тогтоосон олон улсын энэхүү стандартын шаардлага бол нийгмийн даатгалын үйлчилгээнд тавих шаардлагад нэмэлт болж танилцуулж байгаа шаардлага юм. Олон улсын энэхүү стандартад Төлөвлө-Гүйцэтгэ-Шалга-Сайжруул /ТГШС/ мөчлөг болон эрсдэлд суурилсан сэтгэлгээг хослуулсан үйл явцын аргыг хэрэглэсэн. Үйл явцын энэ арга нь байгууллагын үйл явц ба тэдгээрийн харилцан үйлчлэлийг төлөвлөх боломжийг бүрдүүлнэ. ТГШС мөчлөг нь байгууллагын үйл явцыг хангалттай нөөц, зохих удирдлагаар хангах, мөн сайжруулах боломжийг тодорхойлж, хэрэгжүүлэх бололцоог олгоно. Эрсдэлд суурилсан сэтгэлгээ нь байгууллагын үйл явц, чанарын менежментийн тогтолцоог төлөвлөсөн үр дүнгээс хазайхад нөлөөлсөн хүчин зүйлийг тодорхойлох, сөрөг үр дагаврыг бууруулах, бий болсон боломжийг бүрэн ашиглах нөхцлийг бүрдүүлэх сэргийлэх хяналтыг хэрэгжүүлэх бололцоог олгоно. Байнга, улам бүр төвөгтэй болон өөрчлөгдөж байгаа нийгмийн шаардлагыг тогтвортой хангах, үйл ажиллагаагаа ирээдүйн хэрэгцээ ба найдлагад чиглүүлэх, иргэд олон нийтийг



эрсдлээс хамгаалах асуудал нь байгууллагын өмнө сорилтыг бий болгож байна. Энэ зорилтод хүрэхийн тулд эрс өөрчлөлт, инноваци хийх, дахин зохион байгуулалт хийх зэргээр алдааг засах, байнга сайжруулах арга хэмжээнээс гадна бусад төрөл бүрийн сайжруулалтын арга хэмжээг нэмж хэрэгжүүлэх шаардлагатай байж болно.

Аймгийн нийгмийн даатгалын салбарт чанарын удирдлагын тогтолцоог амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд байцаагч, ажилтан бүрийн санаачлага, бүтээлч хандлага, оролцоо, хүчин чармайлт эрхэм чухал болохыг онцлон хамт олныхоо нэгдмэл зорилгынхоо төлөө хамтран хөгжиж дэвжихийг Та бүхэндээ уриалж байна.

ОРХОН АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Д.НАРМАНДАХ



АГУУЛГА

Өмнөх үг

1. Хамрах хүрээ
2. Норматив иш таталт
3. Нэр томъёо ба тодорхойлолт
4. Байгууллагын төлөв байдал
 - 4.1. Байгууллага болон түүний төлөв байдлыг ойлгох
 - 4.2. Сонирхогч талуудын хэрэгцээ ба найдлагыг ойлгох
 - 4.3. Чанарын менежментийн тогтолцооны хамрах хүрээг тодорхойлох
 - 4.4. Чанарын менежментийн тогтолцоо ба үйл явц
5. Манлайлал
 - 5.1. Манлайлал ба амлалт
 - 5.1.1. Ерөнхий зүйл
 - 5.1.2. Хэрэглэгчид төвлөрөх
 - 5.2. Бодлого
 - 5.2.1. Чанарын бодлого боловсруулах
 - 5.2.2. Чанарын бодлогыг мэдээлэх
 - 5.3. Байгууллага дахь үүрэг, хариуцлага, эрх мэдэл
6. Төлөвлөлт
 - 6.1. Эрсдэл болон боломжуудыг авч үзэх арга хэмжээ
 - 6.2. Чанарын зорилтууд, зорилтуудад хүргэхэд чиглэсэн төлөвлөлт
 - 6.3. Өөрчлөлтийг төлөвлөх
7. Тулгуур хүчин зүйл
 - 7.1. Нөөц
 - 7.1.1. Ерөнхий зүйл
 - 7.1.2. Хүмүүс
 - 7.1.3. Дэд бүтэц
 - 7.1.4. Үйл явцыг хэрэгжүүлэх орчин
 - 7.1.5. Мониторинг ба хэмжилтийн нөөц
 - 7.1.6. Байгууллага дахь мэдлэг
 - 7.2. Чадамж
 - 7.3. Мэдлэг ойлголт
 - 7.4. Холбоо харилцаа
 - 7.5. Баримтжуулсан мэдээлэл
8. Ажиллагаа
 - 8.1. Ажиллагааны төлөвлөлт ба хяналт
 - 8.2. Бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавих шаардлага



- 8.3. Бүтээгдэхүүн, үйлчилгээний дизайн ба боловсруулалт хийх
- 8.4. Гаднаас нийлүүлж буй үйл явц, бүтээгдэхүүн, үйлчилгээний хяналт
- 8.5. Үйлдвэрлэл явуулах ба үйлчилгээ үзүүлэх ажлын хяналт
- 8.6. Бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргаж бэлтгэх
- 8.7. Үл тохирол бүхий гаралтын хяналт
- 9. Гүйцэтгэлийн үнэлгээ
 - 9.1. Мониторинг, хэмжилт, шинжилгээ ба үнэлгээ
 - 9.2. Дотоод аудит
 - 9.3. Удирдлагын дүн шинжилгээ
- 10. Сайжруулалт
 - 10.1. Ерөнхий зүйл
 - 10.2. Үл тохирол ба залруулах арга хэмжээ
 - 10.3. Байнгын сайжруулал

Хавсралтууд

-oOo-



НЭГ: ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1.Нийгмийн даатгалын байгууллага

Орхон аймгийн Нийгмийн даатгалын газар нь анх 1976 оны 5 дугаар сард ажлаа эхэлсэн бол мөн оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс тэтгэвэр олгох болсноор 10 дугаар сард “Хөдөлмөр нийгэм хангамжийн хэлтэс” болж, дарга, хөдөлмөр ба тэтгэврийн байцаагч гэсэн 3 орон тоотойгоор байгуулагдсан байна.

Засгийн газрын 2016 оны 8 дугаар сарын 03-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс болон аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлаг болон зохион байгуулагдсан бол Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 344 дүгээр тогтоолоор “Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар” шинээр байгуулагдаж тус хэлтсийн нэр “Нийгмийн даатгалын хэлтэс” болж өөрчлөгдсөн бөгөөд Нийгмийн даатгалын ерөнхий хууль батлагдсантай холбогтойгоор НДЕГ-ын даргын 2023 оны А/169 тоот тушаалаар “Орхон аймгийн Нийгмийн даатгалын газар” болсон. Одоогийн байдлаар:

- Санхүү бүртгэлийн тасаг
- Үйлчилгээний тасаг
- Хамралт, орлого шимтгэлийн тасаг,
- Хяналт шалгалт дотоод аудитын тасаг гэсэн 4 тасагтай 40 орон тоотойгоор Орхон аймгийн хэмжээнд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад нийгмийн даатгалын үйлчилгээ үзүүлж байна. Мөн сүүлийн жилүүдэд нийгмийн даатгалын зарлага жил бүр өсч орлогоосоо давах хандлагатай байгаад дүгнэлт хийж аймаг, орон нутагтай хамтран ажилласны үр дүнд нийгмийн даатгалын 10 төлөөлөгчийг журмын дагуу ажиллуулж байна.

Аймгийн Нийгмийн даатгалын газар нь 2023 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 61,0 тэрбум төгрөгийн орлогын төлөвлөгөөтэй ажиллаж 64,6 тэрбум төгрөгийг оруулан төлөвлөгөөг 106,0 хувиар биелүүлсэн боловч 69,0 тэрбум төгрөгийг давхардсан тоогоор Орхон аймгийн 190,0 гаруй мянган иргэнд олгож, нийгмийн даатгалын үйлчилгээ үзүүлсэн.

2023 оны жилийн эцсийн байдлаар 67.3 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлэхээс 66.9 тэрбум төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 99.4 хувиар биелүүлээд байна. Зарлага 69.0 тэрбум төгрөг зарцуулахаас 88.1 тэрбум төгрөг зарцуулаад байна. Нийт энэ онд 66.9 тэрбум төгрөгийн орлого, 21.6 тэрбум төгрөгийн татаас, 69,0 тэрбум төгрөг зарцуулах зардлын төсөвтэйгээр 2349 аж ахуйн нэгж байгууллагыг



хамруулан ажиллаж, давхардсан тоогоор 266.0 мянган даатгуулагч иргэдэд нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэн ажиллаж байна.

Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын бүтэц

	Нэг.Удирдлага
1	Газрын дарга
	Хоёр.Захиргаа,хяналтын хэлтэс
2	Хэлтсийн дарга
3	Хяналт шалгалтын байцаагч
4	Нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч
5	Хүний нөөц, хуулийн мэргэжилтэн
6	Бичиг хэрэг, дотоод асуудал, хөрөнгө хариуцсан мэргэжилтэн
7	Сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн
8	Мэдээллийн технологийн мэргэжилтэн
9	Архивын ажилтан
10	Үйлчлэгч
11	Төсвийн байгууллагын үйлчилгээний ажилтан
	Гурав.Санхүү бүртгэлийн хэлтэс
12	Хэлтсийн дарга бөгөөд ахлах нягтлан бодогч
13	Сангийн бүртгэл хариуцсан мэргэжилтэн
14	Үйл ажиллагааны нягтлан бодогч
	Дөрөв.Хамралт,орлогын хэлтэс
15	Хэлтсийн дарга
16	Хамралт, орлого, шимтгэлийн өр хариуцсан байцаагч
17	Сайн дурын даатгалын байцаагч
	Тав.Тэтгэвэр,тэтгэмжийн хэлтэс
18	Хэлтсийн дарга
19	Магадлагч эмч
20	Тэтгэврийн хяналтын байцаагч
21	Тэтгэмжийн хяналтын байцаагч
22	Тэтгэврийн тогтоолт олголтын байцаагч
23	Тэтгэмжийн тогтоолт олголтын байцаагч
	5.1. Нэг цэгийн үйлчилгээ, цахим мэдээллийн тасаг
24	Тасгийн дарга
25	Нэг цэгийн үйлчилгээний байцаагч
26	Цахим үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
	Зургаа. Сумын байцаагч



Эрхэм зорилго

Бид Даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэнэ.

Хэтийн зорилго

Манай байгууллага 2030 он гэхэд бүх нийтийн насан туршийн нийгмийн баталгааг хангахуйц чадамжтай, нийгмийн даатгалын цогц үйлчилгээ бүхий Даатгагч болно

Үнэ цэнэ: ШҮХЭР

Ш- ШИЛДЭГ, МЭРГЭШСЭН
Ү- ҮНЭНЧ, ЁС ЗҮЙТЭЙ
Х - ХАМТРАН АЖИЛЛАХ чадвартай
Э - ЭЕЛДЭГ, ТУСЧ
Р- ЭРЧ ХҮЧТЭЙ, БҮТЭЭЛЧ САНААЧЛАГАТАЙ

1.2. Хамрах хүрээ

Даатгуулагч (иргэд)-ийн хэрэгцээ, шаардлага, сэтгэл ханамжид нийцүүлэн Нийгмийн даатгалын үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэх бүхий л үйл ажиллагаа, үйл явцыг /үйл явцын зураглалын дагуу/ хамруулна. Үүнд:

Даатгуулагчдад үзүүлж буй үйлчилгээ:

- Өндөр насны тэтгэвэр
- Тахир дутуугийн тэтгэвэр
- Тэжээгчээ алдсаны тэтгэвэр
- Цэргийн тэтгэвэр
- Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж,
- Жирэмсэн, амаржсаны тэтгэмж
- Оршуулгын тэтгэмж



- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэмж
- Ажилгүйдлийн тэтгэмж
- ЭМД-ын орлого бүрдүүлэх, зарцуулалтад хяналт тавих.

1.3. Хэрэглээ

Энэхүү гарын авлага нь нийгмийн даатгалын үйлчилгээний үйл ажиллагааны чанар хангалтад тавигдах ерөнхий шаардлагуудыг тогтоон чанарын асуудлаарх байгууллагын бодлогыг тодорхойлон, нийгмийн даатгалын байгууллагын чанарын удирдлагын тогтолцоонд холбогдох чанарын хяналт, стандарт үйл ажиллагааны журам, ажлын заавар, бүртгэлийн маягтуудыг хамруулан нийгмийн даатгалын бүхий л үйл ажиллагааг хамрана.

2. Норматив иш таталт

Энэхүү гарын авлагад иш татсан норматив баримт бичиг нь түүний үндэслэл болох заалтуудыг агуулна. Иш татсан норматив баримт бичгийн хамгийн сүүлчийн хэвлэлийг хэрэглэнэ.

- ISO 9000:2005 - Чанарын удирдлагын тогтолцоо-Суурь асуудал, тайлбар толь
- MNS ISO 9001:2016 - Чанарын удирдлагын тогтолцоо –Шаардлага
- MNS ISO 9004:2016-Байгууллагын амжилтыг тогтвортой байлгах-Чанарын удирдлагын хандлага
- ISO 19011:2005 - Чанарын болон байгаль орчны удирдлагын - тогтолцоонд аудит явуулах заавар
- Нийгмийн даатгалын байгууллагын стратегийн баримт бичгүүд

3. Нэр томъёо ба тодорхойлолт, товчлол

Товчилсон үг	Тайлбар
ЧУХ	Чанарын удирдлагын хороо
ЧУТ	Чанарын удирдлагын тогтолцоо
ББНС	Баримт бичгийн нэгдсэн сан
БХМ	Бүртгэл хариуцсан мэргэжилтэн
ISO	Олон улсын стандартын байгууллага
АШБ	Анхан шатны бүртгэл
СҮАЖ	Стандарт үйл ажиллагааны журам



Нэр томъёо	Тайлбар
Чанар	(объектийн) хувийн багц үзүүлэлт нь шаардлага биелүүлэх хир хэмжээ
Шаардлага	Гол төлөв мэдээжийн буюу албан журмын шинжтэй, тогтоосон хэрэгцээ буюу хүсэл
Чанарын гарын авлага	Байгууллагын ЧУТ-г тогтоож буй баримт бичиг
Удирдлага	Байгууллагыг удирдан чиглүүлэх, хянах зохицуулсан үйл ажиллагаа
Хэрэглэгчийн сэтгэл ханамж	Хэрэглэгчийн шаардлага ямар хэмжээнд биелсэнийг хэрэглэгчээс мэдрэх байдал
Чадвар	Уг бүтээгдэхүүнд тавих шаардлагыг хангаж чадахуйц бүтээгдэхүүнийг хийх байгууллагын тогтолцоо буюу үйл явцын чадвар
Удирдлагын тогтолцоо	Бодлого, зорилтуудыг тогтоож тэдгээр зорилтуудад хүрэх тогтолцоо
Чанарын удирдлагын тогтолцоо	Байгууллагыг чанарын талаар удирдан чиглүүлэх, хянах удирдлагын тогтолцоо
Чанарын бодлого	Дээд удирдлагаас албан ёсоор илэрхийлсэн чанарт хамаарах, байгууллагын нийт зорилго ба чиглэл
Чанарын зорилт	Чанарын талаар хийхээр буюу хүрэхээр зорьж эрмэлзсэн зүйл
Чанарын удирдлага	Байгууллагын чанарын талаар удирдан чиглүүлэх, хянах зохицуулагдсан үйл ажиллагаа
Чанарын төлөвлөлт	Чанарын зорилтыг тогтоох, ажлын шаардагдах үйл явц чанарын зорилтыг биелүүлэхтэй холбоотой нөөцийг тодорхойлоход чиглэсэн, чанарын удирдлагын нэг хэсэг
Чанар хангалт	Чанарын шаардлага биелэгдэнэ гэсэн итгэл бий болгоход чиглэсэн, чанарын удирдлагын нэг хэсэг
Чанар сайжруулалт	Чанарын шаардлагыг биелүүлэх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн, чанарын удирдлагын нэг хэсэг
Үр нөлөө	Төлөвлөсөн үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнд хүрсэн байдлын хэмжээ
Хэрэглэгч	Бүтээгдэхүүн, үйлчилгээг хүлээн авдаг байгууллага эсвэл хувь хүн
Үйл явц	Оролтыг гаралт болгон хувиргах харилцан уялдаа буюу харилцан үйлчлэл бүхий багц үйл ажиллагаа
Бүтээгдэхүүн	Үйл явцын үр дүн
Журам	Үйл ажиллагаа буюу үйл явцыг гүйцэтгэх тогтоосон арга зам
Ажлын заавар	Байгууллагын тодорхой чиглэлийн үйл ажиллагааны арга хэлбэр, зохион байгуулалт, дэс дарааллыг нарийвчлан заасан баримт бичиг
Үл тохирол	Шаардлага үл биелж байгаа байдал
Залруулах үйл ажиллагаа	Нэгэнт илэрсэн үл тохирол буюу үл хүсүүштэй бусад байдлын шалтгааныг арилгахын тулд явуулах ажиллагаа
Бүртгэл	Хүрсэн үр дүнг тогтоож буй буюу гүйцэтгэсэн үйл ажиллагааны бодит баримт болж буй баримт бичиг



4. Байгууллагын төлөв байдал

4.1.Байгууллага болон түүний төлөв байдлыг ойлгох

Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын чанарын менежментийн тогтолцооны хүрээнд зорьсон үр дүнд хүрэх, зорилтоо хэрэгжүүлэх боломж, стратеги чиглэлд хамааралтай гадаад, дотоод асуудлыг ийнхүү тодорхойлж байна.

SWOT шинжилгээ

Орхон аймгийн Нийгмийн даатгалын газар нь 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдөр байгууллагын өнөөгийн төлөв байдлыг үнэлэн дотоод болон гадаад орчны нөлөөлөл давуу болон сул тал, аюул болон боломжийг үнэлэн шинжилгээ хийлээ.

Давуу тал	Сул тал
- Ажлын хамт олон зохих түвшинд зөв төлөвшсөн, мэдлэг ур чадвар сайн, нэг ажлаас нөгөөд хөрвөх чадвартай - Удирдлагын баг сайн бүрдсэн ба өөрчлөлт шинэчлэлт, менежментийг дэмждэг. - Нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлдэг тул иргэдийн хандлага сайн даатгуулагчдын тоо өсөх хандлагатай - Техник тоног төхөөрөмж, программ хангамж сайн - Хүн бүрийн хийх ажлын чиг үүрэг тодорхой, ажил тогтмолжсон - Байгууллагын дотоод орчны зохион байгуулалт сайн - Жишиг архивтай	- Хүний нөөцийн дутагдал - Програм хангамж сайн хэдий ч дээд шатны байгууллага, төрийн байгууллагын хоорондын уялдаа холбоо муу - Цалин хангамж, урамшууллын тогтолцоо сул - Шинэ ажилчдын сургалт, хөгжлийн асуудал дутмаг - Хэвлэл мэдээллийн хэрэгслээр реклам, сурталчилгаа муу цацагддаг - Эрүүл мэндийн даатгалын сангаас гарсан зардалд тавих хяналт сул - Байгууллага, даатгуулагчийн өмчийг хамгаалах ажил сул - Олон жил хэвшсэн төрийн албаны арга барил өөрчлөгдөхдөө удаан байх
Боломж	Аюул
- Чадварлаг мэргэшсэн баг бүрдүүлэх боломжтой - Хариуцлага, урамшуулалын систем нэвтрүүлэх боломжтой - Иргэд даатгуулагчдын хандлагыг өөрчлөх, Нийгмийн даатгалын тухай хуулийн мэдлэгээр хангах боломжтой - Хамрагдалтыг нэмэгдүүлэх боломжтой - Гадаад харилцааг өргөжүүлэх, туршлага солилцох боломжтой - Үйл ажиллагааны процессыг хөнгөвчлөх боломжтой. - Нийгмийн даатгалын шинэчлэл үйлчилгээ, орчин үеийн менежмент нэвтрүүлэх боломжтой.	- Эдийн засгийн хямрал - Бухимдсан иргэд даатгуулагч байцаагчдад халдах - Нийгмийн даатгалын тогтолцоонд улс төрийн оролцоо нэмэгдэх - Даатгуулагч итгэл алдрах, гомдол гаргах - Иргэд нийгмийн даатгалын талаар буруу мэдээлэл авах бусдад дамжуулах, даатгуулагч хохирох - Интернэт, цахим сүлжээгээр эзэнгүй худал мэдээлэл тархах - Байцаагчийн зохимжгүй үйлдлээс шалтгаалан байгууллагын нэр хүнд унах - Байцаагчийн ёс зүйн хэм хэмжээ зөрчигдөр нөлөөлөл бий болох



4.2. Сонирхогч талуудын хэрэгцээ ба найдлагыг ойлгох

Даатгуулагчдын болон холбогдох хуулийн болон зохицуулалтын шаардлагыг хангасан нийгмийн даатгалын үйлчилгээг байнга нийлүүлэхэд нөлөөлөх дараах асуудлуудыг доорх байдлаар тодорхойлов.

а/ Чанарын менежментийн тогтолцоонд хамаарах Нийгмийн даатгалын газрын дарга, тасгийн удирдлагууд, байцаагч нар, нийт ажилтан, албан хаагчид, аж ахуйн нэгж, байгууллага, ажил олгогч, иргэд

б/ Эдгээр сонирхогч талуудын сэтгэл ханамжийн эерэг байдал, баталгаатай нийгмийн даатгалын үйлчилгээ

Аймгийн Нийгмийн даатгалын газар нь эдгээр сонирхогч талуудад хамаарах мэдээлэл, төрийн үйлчилгээний хөнгөн шуурхай байдлыг хангах, холбогдох шаардлагад хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх ажлыг тогтмол хийнэ.

4.3. Чанарын менежментийн тогтолцооны хамрах хүрээ

Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын хэмжээнд буюу дотоод талдаа бүхэлд нь энэхүү чанарын удирдлагын тогтолцоог хэрэглэнэ. Гадаад талдаа аймгийн хэмжээнд нийгмийн даатгалын үйлчилгээ авч байгаа иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг хамарсан даатгуулагчдын шаардлагад нийцсэн нийгмийн даатгалын бүх төрлийн үйлчилгээнд хэрэглэх болно.

4.4. Чанарын менежментийн тогтолцоо ба үйл явц

4.4.1. Нийгмийн даатгалын үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах нь нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны үндсэн зарчим юм.

Энэхүү зарчмыг хэрэгжүүлэх, шуурхай байдлыг хангаж ажиллахад нийгмийн даатгалын үйлчилгээнд хамаарах бүхий л процессуудыг тодруулан тэдгээрийн харилцан үйлчлэл ба хамаарлыг тодорхойлсоноор ажилтнуудын үүрэг оролцоо, хариуцлага, нэгж хэсгүүдийн уялдаа холбоо, хамтын ажиллагаа сайжран, ажлын чанарыг дээшлүүлэх үндэс суурь тавигдаж байна.

Нийгмийн Даатгалын байгууллагын дээд түвшиний процессийн зураглал /Зураг -1/ дээр удирдлагын, үндсэн процесс ба туслах процессуудыг тодруулан баримтжуулав.



ДЭЭД ТӨВШИНИЙ ПРОЦЕССИЙН ЗУРАГЛАЛ



Зураг 1

Дээрх зураглалаас харахад иргэд, даатгуулагчийн хэрэгцээ шаардлага, хүлээлтийг танин мэдсэнээр тэдгээрийг хангахын тулд нийгмийн даатгалын бодлого, стратегийн зорилго, зорилтуудыг тодорхойлж, тэдгээрт хүрэх үйл ажиллагааны процессуудыг оновчтой төлөвлөн нийгмийн даатгалын эрх зүй, эдийн засгийн орчныг бүрдүүлж, иргэд, ажил олгогчдыг даатгалд өргөнөөр хамруулж, тэд нарт даатгалын үйлчилгээг хүргэх үндсэн үйл ажиллагааны процессуудын үр ашигтай, үр нөлөөтэй хэрэгжихэд туслах процессуудыг тодруулан уялдаа холбоо, харилцан үйлчлэлийг зөв удирдан иргэд, даатгуулагчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлж чадна. Дээрх процессуудын дэс дараалал харилцан үйлчлэлийг дараахь байдлаар тодорхойлж байна. /Ажлын байр бүрийн үйл явцын зураглалыг энэхүү гарын авлагын хавсралтаар батлав/

Нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээний чанарыг өндөр түвшинд хүргэхийн тулд байгууллагынхаа ЭРХЭМ ЗОРИЛГО, ХЭТИЙН ЗОРИЛГО, ЭРХЭМЛЭХ ҮНЭ ЦЭНЭ-ийг хүн бүрт ойлгомжтойгоор тодорхойлж, энэхүү стратегийн зорилго, зорилтоо амжилттай биелүүлэхийн тулд жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөлтийг оновчтой хийж, хэрэгжилтийг удирдан ажиллана. Энэхүү ажлыг чанартай гүйцэтгэхэд мэргэшсэн, чадварлаг, ёс зүйтэй хүний нөөцийг хөгжүүлэхэд байнга анхаарч хүний нөөцийн бодлогыг



оновчтой зохион байгуулна.

Нийгмийн даатгалын үйлчилгээг чанартай хүргэхэд нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилт, стандарт үйл ажиллагааны журам, зааврын дагуу хяналтыг сайтар хийх менежментийн чадавхийг бэхжүүлэн ажиллах явдал гол үндсэн нөхцөл мөн.

Иргэд даатгуулагчийн хэрэгцээ шаардлага хэрхэн хангагдаж буйг судалж дүн шинжилгээ хийж, шаардлагад нийцүүлэхийн тулд авсан арга хэмжээний тайланг олон нийтэд нээлттэй байлгах нь бидний ажлын чанарын үзүүлэлтийн нэг байдаг.

Дээрхи ажлуудыг өндөр түвшинд хийхийн тулд байгууллага болон ажилтан бүр байнга шинийг суралцаж хөгжиж байх шаардлагатай бөгөөд энэхүү шаардлагыг хангахын тулд процесс бүрийг ажиглаж хэмжиж, задлан шинжилж байх ёстой.

4.4.2. Нийгмийн даатгалын газар нь шаардлагатай хэмжээнд:

а/ үйл явцын шат дамжлагыг дэмжих зорилгоор баримтжуулсан мэдээллийг мөрдөж хадгална.

б/ үйл явц төлөвлөсний дагуу явагдаж байгаад илтгэлтэй байхын тулд баримтжуулсан мэдээллийг хөтөлж хадгална.

5. Манлайлал

5.1. Манлайлал ба амлалт

5.1.1. Ерөнхий зүйл

Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын дарга нь чанарын бодлого, зорилтыг тодорхойлон хамт олондоо таниулан ойлгуулж, үйл ажиллагаандаа дүн шинжилгээ хийх, нөөцөөр тасралтгүй хангах замаар Чанарын удирдлагын тогтолцоог бүрдүүлж, хэрэгжүүлэх, түүний үр нөлөөг сайжруулахад шийдвэр төгс байгаагаа илэрхийлсэн болно. Энэхүү амлалтын хүрээнд Нийгмийн даатгалын байгууллагын эрхэм зорилго, хэтийн зорилго, үнэ цэнийг шинэчлэн томъёолсон. Тэрээр Чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлж, хэвшүүлэх, тасралтгүй сайжруулах үүргийг хүлээдэг. Энэ хүрээнд дараахь арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

- Хэтийн зорилго, эрхэм зорилго, эрхэмлэх үнэ цэнийг бүх ажилтнуудад ухуулан таниулах үйл ажиллагааг мэдээлэл харилцааны олон төрлийн хэлбэрээр, байнга зохион байгуулдаг. Мөн үйл ажиллагааны үр дүн, ЧУТ-ны хэрэгжилт, тасралтгүй сайжруулалтыг нийт ажилтнуудад тогтмол тайлагнана.



- Нийгмийн даатгалын газар нь чанарын бодлогоо тодорхойлж, бодлогын хэрэгжилтийг өдөр тутмын үйл ажиллагаанд хэрхэн

хэрэгжиж байгаа болон тэдгээрийн үр дүн нь хамтран ажиллаж буй талуудын хүсч байгаа хүлээлтэд хэрхэн нийцэж байгаад хяналт тавьж, тодорхой давтамжтайгаар дүн шинжилгээ, дотоод аудит хийж ажиллана.

- Нийгмийн даатгалын газрын чанарын зорилтууд болон процессын гүйцэтгэлийн хэмжүүр үзүүлэлтүүдийг тогтоосон бөгөөд бүх тасаг, байцаагчид, ажилтнууд, сум дахь ажилтнууд хэрэгжилтийг ханган ажиллана.

- Удирдлагын дүн шинжилгээний хурлыг ЧУТ-ны тогтоосон шаардлага, процессийн дагуу явуулна.

- Үйл ажиллагаагаа хэвийн явуулахад шаардлагатай нөөцүүдийг төлөвлөж, бүрдүүлнэ.

5.1.2. Хэрэглэгчид төвлөрөх

Аймгийн Нийгмийн даатгалын газрын удирдлага нь иргэд, даатгуулагчийг дээдэлсэн хандлагыг бүхий л үйл ажиллагаандаа төлөвшүүлж, чанарын соёлыг хөгжүүлэхийг эрхэмлэн ажилладаг.

Иргэд, даатгуулагчийн хэрэгцээ шаардлагыг таньж мэдэх үйл ажиллагааг системтэйгээр хэрэгжүүлэх бөгөөд Нийгмийн даатгалын хэлтсийн даргын 2017 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн А/19 дүгээр тушаалаар баталсан “Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн стандарт/түвшинг хэмжих журам”-ыг мөрдөж ажиллана. /СҮАЖ-ОАНДХ-02-2017/

Орхон аймгийн Нийгмийн даатгалын газар нь хэрэглэгчид төвлөрөх, хэрэглэгчдэд нийгмийн даатгалын үйлчилгээний үйл явц, хууль тогтоомж, түүний ач холбогдолыг соён гэгээрүүлэх, ингэснээр нийгмийн даатгалын үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор доорх төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, үр дүнд хүрч байна. Үүнд:

- “Internship” буюу “Нийгмийн даатгалын элч” хөтөлбөр
- “Нийгмийн даатгалын бэлэг” хөтөлбөр
- “Нийгмийн даатгалын төлөөлөгч” төсөл хөтөлбөр
- “Нийгмийн даатгал-365” хөтөлбөр
- Call center үйлчилгээнүүдийг нэвтрүүлэн хэрэгжүүлж, хэрэглэгчид төвлөрөх зорилтын хүрээнд хэрэглэгчдэд мэдээ мэдээлэл түгээх, сургалт сурталчилгаа явуулах зорилгоор “Монгол шуудан” ХХК, орон нутгийн 8 телевиз, “Шинэ мэдээ сонин”, 6 банкны



салбар, “Монголын төмөр зам” ХНН, нийтийн тээврийн такси үйлчилгээтэй гэрээ, санамж бичиг байгуулан хамтран ажиллаж, нийт 59000 сурталчилгааны тараах материал түгээсэн байна.

Эдгээр ажлын үр дүнд 2017 онд нийт давхардсан тоогоор 266.0 мянга гаруй хэрэглэгчид хүрч ажиллан 88.1 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Мөн үүний үр дүнд албан журмын даатгалд 28650 даатгуулагч, сайн дурын даатгалд 6385 даатгуулагч хамрагдаж нийт 35035 даатгуулагчийн хамралттай байгаа нь өнгөрсөн оныхоос энэ 2 үзүүлэлт хамт өссөн үр дүн үзүүлжээ.

Хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчид, ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдэд нийгмийн даатгалын ач холбогдол, хууль тогтоомжийг сурталчлах зорилгоор ажиллаж байгаа нийгмийн даатгалын төлөөлөгчид нь зах, худалдаа үйлчилгээний газрууд хуваарийн дагуу ажиллаж 349 аж ахуйн нэгж, 4800 гаруй иргэнд мэдээлэл өгсөн байна.

Нийгмийн даатгалын үйлчилгээг сурталчилах, хэрэглэгчдэд хүргэх зорилгоор www.orhon.ndaatgal.mn сайт, www.facebook.com/orhon аймгийн нийгмийн даатгалын газар, page хуудсыг байнга ажиллуулж, Орхон аймгийн Нийгмийн даатгалын газар youtube хуудас зэрэг олон нийтийн сүлжээнд мэдээ мэдээлэл, асуулт хариулт тавьж, live хийн 10000 гаруй түгээсэн байна. Мөн гадаад оронд ажиллаж амьдарч байгаа Монголчуудад positive Mongolians онлайн төслөөр дамжуулж сурталчилгаа явуулж байна.

5.2. Бодлого

5.2.1. Чанарын бодлого боловсруулах

Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын чанарын бодлого нь Эрхэм зорилго, хэтийн зорилготой уялдсан, Чанарын удирдлагын тогтолцооны тасралтгүй сайжруулалтад дээд удирдлагын амлалтыг баримтжуулсан баримт бичиг юм.

Чанарын бодлого: “Нийгмийн даатгалын байгууллага нь өсөн дэвших эрмэлзэлтэй мэргэшсэн, чадварлаг, ёс зүйтэй хүний нөөцөд түшиглэн үйл ажиллагаагаа цаг үргэлжид сайжруулан, түншлэл хамтын ажиллагааг дэмжин, харилцан үр ашигтай хамтран ажиллаж, сайн засаглалыг хэрэгжүүлэн нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн чанартай үйлчилгээг ДААТГУУЛАГЧДАД хүргэнэ”

Чанарын бодлогын агуулгыг бүх ажилтануудад танилцуулж, бодлогын хэрэгжилтэнд тэдний үүрэг оролцоог чухал болохыг бүх



төрлийн хэлбэр, сувгаар тайлбарлан таниулдаг.

Чанарын бодлогын хэрэгжилтийн талаар Удирдлагын дүн шинжилгээний хурлаар хэлэлцдэг.

НДБ-ын чанарын зорилтууд нь чанарын бодлогын хэрэгжилтийн үр дүнг тодорхойлох хэмжүүрүүд болдог.

5.2.2. Чанарын бодлогыг мэдээлэх

Чанарын бодлого нь манай байгууллагын байнга дагаж мөрдөн, зорьж ажиллах чухал бодлогын баримт бичиг бөгөөд байгууллага дотор болон гадагшаа чиглэсэн мэдээллийг байнга, тогтмол, тасралтгүй явуулна.

а/ баримтжуулсан мэдээлэл байдлаар хүртээмжтэй байх ба мөрдөж хадгална.

б/ байгууллагын хэмжээнд чанарын бодлого, зорилтыг ажлын өрөө тасалгаа бүрт хэвлэн байрлуулж, хурлын танхим, мэдээллийн самбар зэрэгт олны хүртээл болгон мэдээлнэ.


в/ иргэд олон нийт, аж ахуйн нэгж байгууллагууд, даатгуулагчид, сонирхогч талуудад байгууллагын чанарын бодлогыг хүртээмжтэй мэдээллээр хангах зорилгоор төв, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллахын зэрэгцээ аймгийн болон байгууллагын вэб сайт, хотын төвийн төвлөрөл ихтэй хэсэг, автобусны буудалд байрлуулсан LED дэлгэц, мэдээллийн бусад хэрэгслээр мэдээлж, сурталчилна.

5.3. Байгууллага дахь үүрэг, хариуцлага, эрх мэдэл

Удирдлагын үүрэг хариуцлага, эрх мэдлийг байгууллагын хэмжээнд тодорхойлон, бүх ажилтнуудад танилцуулдаг.

Ажилтнуудын үүрэг, хариуцлагыг ажлын байр тус бүрийн онцлог, ялгаанд тохирсон ажлын байрны тодорхойлолт болон ажлын байранд тавигдах шаардлагад тусган баримтжуулдаг

Нийгмийн даатгалын газрын хэмжээнд газрын даргын удирдлагад тасгийн дарга нар харъяалагдан захиргааны удирдлагыг хэрэгжүүлнэ. Энэ байгууллага дахь үүрэг, хариуцлага, эрх мэдлийг Нийгмийн даатгалын газрын “Хөдөлмөрийн дотоод журам” -аар зохицуулна.



6.Төлөвлөлт

6.1.Эрсдэл болон боломжуудыг авч үзэх арга хэмжээ

6.1.1. Нийгмийн даатгалын багц хуулийг хэрэгжүүлэх стратегийн зорилтуудыг тодорхойлж жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажилладаг.

ЧУТ-ны төлөвлөлтийн ач холбогдол нь гүйцэтгэлийн оновчтой түлхүүр хэмжүүр үзүүлэлтүүдийг тодорхойлон, процессуудын явц, гүйцэтгэлийг удирдах баталгаа болдог.

Процессуудын гүйцэтгэлийг үнэлэх, сайжруулах арга хэмжээнүүдийг тодорхойлохын тулд гүйцэтгэлийн түлхүүр хэмжүүр үзүүлэлтүүдэд тогтмол хугацаанд дүн шинжилгээ хийж, байнгын сайжруулалтыг хийж ажиллана.

Байгууллага нь чанарын менежментийн тогтолцоог төлөвлөхдөө 4.1-д заасан асуудлууд, 4.2-т заасан шаардлагыг үндэслэн эрсдэл болон боломжуудыг тодорхойлоход дараах асуудлаар авч үзнэ.



а/ чанарын менежментийн тогтолцоо төлөвлөсөн үр дүн буюу байгууллагын алсын хараа, эрхэм зорилго, чанарын бодлогод хүрэх менежмент, байгууллагын соёл, мэдлэг, туршлага, нөөц хангалттай байгаа

б/ иргэд, даатгуулагчдын сэтгэл ханамжийн түвшинг дээшлүүлэх

в/ хүсээгүй үр дүнгээс сэргийлэх буюу бууруулах зорилгоор эрсдлийн менежментийг нэвтрүүлнэ.

6.1.2. Байгууллага нь дараах арга хэмжээг төлөвлөнө. Үүнд:

- Хүрэх үр дүн, үр нөлөө, түвшин
- Салбарт болон газарт учрах эрсдэл

6.2. Чанарын зорилтууд, зорилтуудад хүрэхэд чиглэсэн төлөвлөлт

6.2.1. Нийгмийн даатгалын газар нь чанарын менежментийн тогтолцоонд шаардлагатай холбогдох чиг үүрэг, түвшин, үйл явцууд дахь чанарын зорилтуудыг доорх байдлаар тогтоож байна. Энэхүү чанарын удирдлагын эрсдэлийн харилцааг НДХ-ийн даргын 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/24 дүгээр тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын хэлтсийн эрсдэлийн менежментийн журам / зарчим ба заавар” / СҮАЖ-ОАНДХ-05-2017/-аар зохицуулна.

Чанарын зорилтууд нь:

1. Өсөн дэвших эрмэлзэлтэй мэргэшсэн, чадварлаг, ёс зүйтэй хүний нөөцийг бүрдүүлнэ.

- Нийт ажилтнууддаа шинэ ба шинэлэг мэдээлэл, мэдлэг олгох сургалтын тоог нэмэгдүүлж 1 ажилтанд ноогдох дундаж цагийг нэмэгдүүлэх

- Шинээр ажилд орсон албан хаагчдад дадлагажих боломжийг бүрдүүлж, хууль тогтоомж, ёс зүй, харилцааны талаарх мэдлэг олгох сургалтанд бүрэн хамруулах

- Ажилтан албан хаагчдын зан харилцаа, ёс зүйтэй холбоотой гомдлыг бууруулж ажиллах

2. Нийгмийн даатгалын үйл ажиллагаагаа цаг үргэлжид сайжруулж, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

- Процессийн явцын хяналтыг сайжруулан ажилтан албан хаагчдын алдаа гаргахаас урьдчилан сэргийлж үл тохирлыг бууруулах

- Илэрсэн үл тохирлыг бүрэн залруулж дахин гарахаас урьдчилан



сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах

- Засгийн газар, яам болон дээд газраас ирүүлсэн хууль тогтоомжийн биелэлтийн түвшинг байнга дээшлүүлэх

3.Түншлэл хамтын ажиллагааг дэмжин харилцан үр ашигтай хамтран ажиллах

- Харилцагч байгууллагын гэрээний биелэлтийн түвшинг байнга дээшлүүлэх

- Даатгуулагчийн сэтгэл ханамжийг байнга нэмэгдүүлэх

- Харилцагч байгууллагуудад тавигдах шаардлага, шалгууруудыг боловсронгуй болгож, түүнд нийцсэн байгууллагуудын тоог байнга нэмэгдүүлэх

4.Сайн засаглалыг хэрэгжүүлж, ил тод байдлыг хангаж ажиллана

- Санхүүгийн данс, тайлан мэдээ болон үйл ажиллагааны талаарх мэдээллийг ил тод болгох

- Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагуудад “БИД АВИЛГАГҮЙ ХАМТ ОЛОН” уриа хөдөлгөөнийг өрнүүлж, “АВИЛГААС ТАТГАЛЗСАН ХАМТ ОЛОН” болно.

5.Даатгуулагчдад хэрэгцээ шаардлагад нийцсэн чанартай үйлчилгээг хүргэнэ.

- Ажил олгогчоос ирүүлсэн санал гомдлын тоо хэмжээг тасралтгүй бууруулах

- Иргэдэд олгох тэтгэвэр, тэтгэмжийн тогтоолт, олголтыг хуулийн хугацаанд хөнгөн шуурхай шийдвэрлэх

- Ажил олгогч даатгуулагчдын мэдээллийн санг үнэн зөв бүрдүүлэх, иргэдэд хөнгөх шуурхай, соёлтой, хүнд сурталгүй үйлчилж ажиллах

6.2.2. Чанарын зорилтуудад хүрэх төлөвлөлт хийхийн тулд байгууллага нь:

а/ чанарын зорилго, зорилтуудын хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүр батлан хэрэгжүүлэх

б/ санхүүгийн болон материаллаг бааз, хүний нөөцийг зөв төлөвлөх, Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөртэй ажиллах

в/ байгууллагын чанарын бодлого, зорилго зорилтуудын төлөвлөлт, хэрэгжилтийг байгууллагын дарга, чанарын удирдлагын хороо, чанарын менежер хариуцна.

г/ энэхүү чанарын гарын авлагыг 2 жилийн хугацаатай



хэрэгжүүлж, дараагийн үе шатыг төлөвлөнө.

д/ үр дүнг батлагдсан хуваарийн дагуу үнэлэх бөгөөд байгууллагын үйл ажиллагааны үр дүнг хагас, бүтэн жилээр дүгнэхдээ чанарын удирдлагын тогтолцооны асуудлыг хамруулна.

6.3. Өөрчлөлтийг төлөвлөх

Нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх стратегийн зорилтуудыг тодорхойлж жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажилладаг. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төлөвлөлт, хэрэгжилт, цаг үеийн байдалтай уялдуулан тухай бүр баримтжуулсан мэдээлэл хөтлөн өөрчилж болно.

7.Тулгуур хүчин зүйл

7.1. Нөөц

7.1.1. Ерөнхий зүйл

Нийгмийн даатгалын байгууллагын хамгийн чухал нөөцийн нэг нь өсөн дэвших эрмэлзэлтэй мэргэшсэн чадварлаг, ёс зүйтэй ажилтнууд юм.

Даатгалын үйлчилгээг иргэд, даатгуулагчдад хөнгөн шуурхай, чанартай хүргэхийн тулд ажилтнууд зохих дадлага туршлагатай, ур чадвартай байх шаардлагатай.

- Нийгмийн даатгалын байгууллагын чиг үүргийг амжилттай хэрэгжүүлэх чадвар бүхий хүний нөөцийг бүрдүүлнэ.

- Шинэ ажилтан сонгохдоо нийгмийн даатгалын байгууллагын дотоод журмыг баримтална./СҮАЖ-ДЖ-2018/

- Төрийн албан хаагчийн шалгаруулалтад тэнцсэн боловч ажлын байрны

захиалгаас илүү гарсан хүмүүсийг нөөцөд бүртгэн цаашид сул орон тоог нөхөхөд анхаарна.

7.1.2. Хүмүүс

Нийгмийн даатгалын газар нь чанарын менежментийн тогтолцоог үр нөлөөтэй хэрэгжүүлэх болон үйл явцын хяналт ба ажиллагаанд шаардагдах ажилтнуудыг тодорхойлж, бий болгоно.

Нийгмийн даатгалын газрын даргын 2023 оны А/06 дугаар тушаалаар Чанарын удирдлагын хороо, Баримт бичиг боловсруулах баг, Идэвхжүүлэлтийн баг, Бүтээмжийн баг, Дотоод хяналт шалгалтын багийг тус тус томилон ажиллуулж байна. Энэхүү тушаалаар



байгуулагдсан хороо, ажлын хэсэг нь нийгмийн даатгалын газрын хэмжээнд чанарын удирдлагын тогтолцоог хариуцан хэрэгжүүлж, зохион байгуулах үүрэг хүлээнэ.

7.1.3. Дэд бүтэц

Нийгмийн даатгалын газар нь ажил олгогч, иргэд, даатгуулагчдад үзүүлж буй үйлчилгээний үйл явцыг хэрэгжүүлэх, үйлчилгээг тохирсон байлгахад шаардлагатай дэд бүтцийг тодорхойлон, бий болгож, хэвийн ажиллуулна. Үүнд доорх дэд бүтцийг хамруулж байна.

а/ Барилга ба дагалдах байгууламжууд: Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын барилга нь нийт 348 м.кв бөгөөд 1990 оны 02 дугаар сарын 01-ний өдөр 250594811,51 сая төгрөгийн анхны өртөгтэйгөөр ашиглалтанд орсон.

б/ Тоног төхөөрөмж, материал ба програм хангамж: 2017 оны жилийн эцсийн байдлаар нийт 68999248,3 сая төгрөгийн үлдэх өртөгтэй машин тоног төхөөрөмж ашиглан хэвийн нөхцөлд ажиллаж байна. Нийгмийн даатгалын газрын байцаагч, албан хаагчид албан хэрэгцээнд доорх програм хангамжийг хэрэглэнэ.

Гадаад орчны буюу вэб програмууд:

- Нэгдсэн систем - <https://sicos.ndaatgal.mn/#/home-menu>
- Нэгдсэн лавлагаа - <http://10.9.11.2:808/ndlav/Login.aspx>
- Шимтгэл төлөлтийн тодорхойлолт - <http://local.ndaatgal.mn/lav/login>
- Албаны е-мэйл - <https://mail.ndaatgal.mn/webmail/login/>
- Зар мэдээ - <http://10.9.0.5/zarmedee/>
- Хэрэглэгчийн удирдлагын програм - <http://10.9.0.5/siadmin/login.aspx>
- Шимтгэлийн цахим систем - <https://portal.ndaatgal.mn/#/landing>
- Хяналтын мониторинг - <http://10.9.0.5/monitoring/>
- Цахим хувийн хэрэг - <http://192.168.20.237/pension/dashboard/>
- Сайн дурын даатгалын програм - <https://app.ndaatgal.mn:811/sd/#/account/login>
- Динамик платформ - <https://surgalt.ndaatgal.mn/#/login>

Дотоод орчны програм:

- Шимтгэлийн тооцооны программ – deduction.exe
- Тэтгэмжийн тооцооны програм – tetgemj.exe
- Тэтгэврийн тооцооны програм – pension.exe
- Сангийн харилцахын програм – hariltsah.exe
- Сангийн сарын мэдээний програм – sarmedee.exe
- YOMШӨ-ний даатгалын програм – uorsz.exe



- Үйл ажиллагааны санхүүгийн програм – Sanhuu.exe

- Хүний нөөцийн програм – Green ERP

в/ Тээврийн нөөц: 2015 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр 42700000 мян. төгрөгийн анхны өртөгтэй HYUNDAI ELANTRA маркын автомашиныг албан хэрэгцээнд хэрэглэж байна.

г/ Мэдээлэл ба харилцаа холбооны технологи: Интернетийн эх үүсвэр нь Монголын цахилгаан холбоо, mobinet-ийг албан хэрэгцээнд ашиглана.

7.1.4. Үйл явцыг хэрэгжүүлэх орчин

а) Ажил хийхэд тохиромжтой ажлын нөхцлийг бүрдүүлэхийн тулд мэргэжлийн байгууллагаар ажлын байрны үнэлгээ хийлгүүлж, ажилтнуудыг ажлаа чанартай сайн хийж гүйцэтгэхэд таатай орчныг бүрдүүлж ажиллана.

б) Төрийн албаны хуулийн заалтын дагуу ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган шийдвэрлэж байна.

7.1.5. Мониторинг ба хэмжилтийн нөөц

7.1.5.1. Ерөнхий зүйл

Нийгмийн даатгалын газрын дээд удирдлага дараах зорилгоор байгууллагын орчинд мониторинг хийх, мэдээлэл цуглуулж, удирдах үйл явцыг бий болгоно. Үүнд:

- Одоо болон ирээдүйн хэрэгцээ ба холбогдох сонирхогч талуудын хүлээлтийг тодорхойлох болон ойлгох,
- Давуу тал, сул тал, боломж ба аюул заналыг үнэлэх,
- Өөр, өрсөлдөх чадвартай эсвэл шинэ бүтээгдэхүүний хэрэгцээг тодорхойлох,
- Одоо байгаа, шинээр бий болох даатгуулагчид болон үйлчилгээний зохицуулалтыг үнэлэх,
- Хууль, эрхзүйн шаардлагын одоогийн нөхцөл байдал, хүлээгдэж буй өөрчлөлтийг урьдчилан харах,
- Хөдөлмөрийн зах зээл ба түүний байгууллагын ажиллагсдад үзүүлэх нөлөөг ойлгох,
- Байгууллагын үйл ажиллагаанд хамаатай нийгэм, эдийн засгийн чиг хандлага ба орон нутгийн соёлын онцлогийг ойлгох,
- Байгалийн нөөцийн хэрэгцээ ба түүнийг урт хугацааны туршид хамгаалах асуудлыг тодорхойлох,



- Нийгмийн даатгалын газрын болон үйл явцын чадамжийг үнэлэх.

Нийгмийн даатгалын газрын иргэд олон нийт, аж ахуйн нэгж байгууллага, даатгуулагчдад үзүүлж буй үйлчилгээ энэхүү стандартын шаардлагад тохирч байгааг нотлоход ашиглаж байгаа мониторинг, хэмжилтийн үр дүнгийн хүчин төгөлдөр, найдвартай байдлыг хангахад шаардлагатай нөөцийг тодорхойлж байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ мониторинг нь нийгмийн даатгалын салбарын үйл ажиллагааны онцлог төрөлд тохирсон байна.

Байгууллагын үйл ажиллагаа тасралтгүй, жигд, тогтмол байх бөгөөд хэвийн үйл ажиллагаатай байна.

Нийгмийн даатгалын газар нь захиргааны байгууллагын

хяналт шинжилгээ, үнэлгээний нийтлэг журмыг үйл ажиллагаандаа мөрдөх бөгөөд гүйцэтгэлийн болон үр дүнгийн үнэлгээг тогтмол хийнэ.

Нийгмийн даатгалын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний нөөц нь:

Хууль, эрх зүйн: Аймгийн Засаг даргын 2017 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн А/621 дүгээр захирамжаар батлагдсан “Аймгийн хэмжээнд мөрдөх бодлогын баримт бичгийн хэрэгжилт, Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”,

Хүний: Нийгмийн даатгалын газрын даргын тушаалаар байгуулагдсан “Чанарын удирдлагын хороо”, “Дотоод аудитын баг”, “Хяналт шинжилгээ, үнэлгээний баг”

Санхүүгийн: Байгууллагын төсөв

Мэдээллийн: Нийгмийн даатгалын газрын албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа компьютер, тоног төхөөрөмж, энэхүү чанарын гарын авлагын 7.1.3.6-д заасан програм хангамж, холбогдох журмууд.

7.1.5.2. Хэмжлийн нэгж дамжуулалт

Нийгмийн даатгалын газрын удирдлага эрхэм зорилго, алсын хараа, бодлого, стратеги ба зорилтыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн үр дүнд хүрэх явцыг үнэлнэ. Хэмжилт ба задлан шинжилгээг үйл явцын мониторинг хийх, гүйцэтгэлийн үнэлгээ ба үр дүнтэй шийдвэр гаргахад шаардлагатай мэдээлэл цуглуулах, бэлтгэхэд ашиглана.



Аймгийн Засаг даргын 2017 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн А/621 дүгээр захирамжаар батлагдсан “Аймгийн хэмжээнд мөрдөх бодлогын баримт бичгийн хэрэгжилт, Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг мөрдөн ажиллах нь хэмжилт ба дүн шинжилгээний үйл явцыг амжилттай болгох гол үзүүлэлт юм.

Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлттэй холбоотой мэдээллийг цуглуулахад хэрэглэх арга нь хэрэгжих боломжтой бөгөөд байгууллагад тохирсон байна. Үүнд:

- Эрсдэлийн үнэлгээ ба Нийгмийн даатгалын газрын эрсдэлийн үнэлгээ хийх журам
- Хэрэглэгч болон бусад сонирхогч талуудын сэтгэл ханамжийн талаар хийсэн ярилцлага, асуулга, судалгаа. Судалгааг Нийгмийн даатгалын хэлтсийн даргын 2017 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн А/19 дүгээр тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын хэлтсийн үйлчилгээний сэтгэл ханамжийн судалгаа авах журам”-ыг баримтлана.
- Харьцуулах судалгаа
- Ханган нийлүүлэгч болон харилцагч байгууллага, ажил олгогч, даатгуулагчдын гүйцэтгэлийн үнэлгээ
- Үйл явцын хувьсал, үйлчилгээний шинж чанарын мониторинг ба бүртгэл

7.1.6. Байгууллага дахь мэдлэг

Нийгмийн даатгалын байгууллагын хамгийн чухал нөөцийн нэг нь өсөн дэвших эрмэлзэлтэй мэргэшсэн чадварлаг, ёс зүйтэй ажилтнууд юм.

Даатгалын үйлчилгээг иргэд, даатгуулагчдад хөнгөн шуурхай, чанартай хүргэхийн тулд ажилтнууд зохих дадлага туршлагатай, ур чадвартай байх шаардлагатай.

- Нийгмийн даатгалын байгууллагын чиг үүргийг амжилттай хэрэгжүүлэх чадвар бүхий хүний нөөцийг бүрдүүлнэ.
 - Шинэ ажилтан сонгохдоо нийгмийн даатгалын байгууллагын дотоод журмыг баримтална.
 - Төрийн албан хаагчийн шалгаруулалтад тэнцсэн боловч ажлын байрны захиалгаас илүү гарсан хүмүүсийг нөөцөд бүртгэн цаашид сул орон тоог нөхөхөд анхаарна.
- Сургалт ба чадавх бүрдүүлэлт



- а) Нийгмийн даатгалын байгууллагын ажилтнууд Нийгмийн даатгалын тухай хуулийг чанартай зөв хэрэгжүүлэхийн тулд мэргэжлийн сургалтанд байнга хамрагдаж, мэргэшлийн болон хууль эрх зүйн мэдлэг мэргэшил, арга зүйгээ байнга дээшлүүлж байх ёстой.
- б) Нийгмийн даатгалын байцаагч нарын мэргэшлийн сургалтын хөтөлбөрийн дагуу судалвал зохих сэдвүүд, кредит цагийг бүрэн эзэмшүүлэх ажлыг эрчимжүүлнэ.
- в) Шинээр орсон ажилтнуудыг сургалтанд хамруулж ажилдаа богино хугацаанд дасан зохицох, дадлагажихад анхаарна.
- д) Сургалтад өндөр хөгжилтэй орнуудын даатгалын байгууллагуудын тэргүүн туршлага, арга зүйг эзэмших, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх ажлыг эн тэргүүний зорилго болгоно.
- е) Хүний нөөцийн боловсрол, сургалт, дадлага, туршлагын талаарх зохих бүртгэлийг төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний маягтын дагуу хөтөлж баримтжуулан байнга баяжуулж байна.

Байгууллагад хамаарах онцлог мэдлэг бий болгох

Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын нийт ажиллагсдын 27,5 хувь нь 5-аас дээш, 12,5 хувь нь 10-аас дээш, 7,5 хувь нь 20-оос дээш жил эрүүл мэнд, нийгмийн даатгалын салбарт ажиллаж байгаа бол 30 хувь нь 10-аас дээш, 2,5 хувь нь 20-оос дээш жил төрийн албанд ажилласан туршлагатай байна. Үлдсэн 27,5 хувь нь шинээр төрийн албанд ажиллаж байгаа шинэ албан хаагчид юм. Үүнээс магистр 5, бакалавр 35 байна.

Эдгээр төрийн албан хаагчдыг эрүүл мэнд, нийгмийн даатгалын салбар болон төрийн албанд суралцуулж зөв мэдлэг хандлагатай болгон төлөвшүүлэхийн тулд дадлага туршлагатай ажилтан бүр шинэ залуу ажиллагсдыг халамжлан хүмүүжүүлж, төлөвшүүлж ажиллана. Үүний үр дүнд байгууллагад хамаарах онцлог мэдлэг бий болж, зөв хандлага соёл төлөвшинэ. Энэ нь байгууллагын зорилтуудыг хангахад ашигладаг ба хуваалцдаг мэдээлэл юм.

7.2. Чадамж

Байгууллага дараах зүйлийг хэрэгжүүлнэ. Үүнд:

Аймгийн Нийгмийн даатгалын газрын дарга Удирдлагын төлөөлөгчийг томилно. Удирдлагын төлөөлөгч нь дараахь үүрэг хариуцлага, эрх мэдэлтэй байна. Үүнд:



- ЧУТ-г хөгжүүлэх, хэрэгжүүлэх, хэвшүүлэх болон ЧУТ-ны баримтжуулалтад хяналт тавих;
 - ЧУТ-ний хэрэгжилтийг танилцуулах, дүн шинжилгээ хийх, үнэлэх, сайжруулах;
- Мөн Нийгмийн даатгалын газрын чанарын дотоод аудит болон удирдлагын дүн шинжилгээний хурлыг төлөвлөх, зохион байгуулах;
- ЧУТ шаардлагуудыг биелүүлж, Чанарын бодлого, зорилтуудыг хэрэгжүүлэхэд бүх ажилтнуудын оролцоо, хувь нэмэр чухал болохыг ойлгуулах;
 - Байгууллагын хэмжээнд хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэхийн ач холбогдлыг таниулах.
 - Зохих боловсрол, сургалт, туршлагад үндэслэн ажилтнуудын чадамжийг магадлах
 - Шаардлагатай чадамжийг эзэмшүүлэх арга хэмжээ авах ба эдгээр арга хэмжээний үр нөлөөтэй байдлыг үнэлэх
 - Чадамжийг нотлох холбогдох баримтжуулсан мэдээллийг хөтөлж, хадгалах

7.3. Мэдлэг ойлголт

Нийгмийн даатгалын газар нь өөрийн хяналтан дор ажиллаж байгаа ажилтнууд дараах зүйлийг мэдүүлж ойлгуулна. Үүнд:

а/ чанарын бодлого

б/ хамаарах чанарын зорилтууд

в/ гүйцэтгэл сайжирсны үр ашгийг хамруулсан, чанарын менежментийн

тогтолцооны үр нөлөөнд тэдгээрийн үзүүлэх хувь нэмэр

г/ чанарын менежментийн тогтолцооны шаардлагыг хангаагүйгээс гарах үр дагавар

7.4.Холбоо харилцаа

Нийгмийн даатгалын байгууллагын удирдлага нь ЧУТ-ны хэрэгжилтийн явц, үр нөлөөний талаархи мэдээллийг нийт ажилтнуудын хурал, самбар, цахим хуудас, цахим шуудан зэрэг олон төрлийн мэдээллийн сувгуудаар, тодорхой давтамжтайгаар хүргэхэд анхаарч ажилладаг.

Нийгмийн даатгалын газар нь чанарын менежментийн тогтолцоонд хамаарах дотоод болон гадаад холбоо харилцааны асуудлыг тодорхойлно. Үүнд:

а/ юуг мэдээлэх



- б/ хэзээ мэдээлэх
- в/ хэнд мэдээлэх
- г/ хэрхэн мэдээлэх
- д/ хэн мэдээлэх

7.5. Баримтжуулсан мэдээлэл

7.5.1. Ерөнхий зүйл

Нийгмийн даатгалын газрын Чанарын удирдлагын тогтолцооны баримт бичиг нь дараахь зүйлийг багтана:

- a. Чанарын бодлогын баримт бичиг
 - b. Чанарын зорилтууд
 - c. Чанарын гарын авлага/ Чанарын хяналтын журмууд
 - d. Стандарт үйл ажиллагааны журмууд/ Ажлын зааврууд
 - e. Үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжүүлэлт, хяналтанд хамаарах бүх баримт бичгүүд. Бичиг баримтын агуулга, үүсэл гарал, хэрэглээнээс хамаарсан баримт бичгүүд
 - f. Процессуудын хэрэгжилт, үр дүнд хамаарах бүртгэлүүд
- Нийгмийн Даатгалын Байгууллагын ЧУТ-ны баримтжуулалт нь ЧУТ-г хэрэгжүүлэх, хэвшүүлэх, сайжруулах шаардлагуудыг тусгасан Чанарын гарын авлага, Чанарын хяналтын журмууд, стандарт үйл ажиллагааны журам, ажлын заавруудаас бүрдэнэ. Удирдлагын төлөөлөгч нь ЧУТ-ны баримтжуулалтыг ББНС-ийн тусламжтайгаар удирдана.

Чанарын гарын авлага

Нийгмийн даатгалын байгууллагын Чанарын гарын авлагад дараахь зүйлсийг багтаав. Үүнд:

- a) ЧУТ-ны хамрах хүрээ, түүний үндэслэл;
- b) Чанарын удирдлагын тогтолцооны баримтжуулсан журмууд;
- c) НДБ-ын үйл ажиллагааны бүх процессуудын харилцан үйлчлэл ба хамаарал зэргийг багтаав.

Нийгмийн даатгалын байгууллагын ажилтнууд нь дотоод сүлжээнд байршуулсан чанарын бодлого, чанарын зорилт, чанарын гарын авлагыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөнө.

Баримт бичгийн хяналт

Чанарын удирдлагын тогтолцоонд шаардагдах баримт бичгүүд нь хяналттай байвал зохино. Чанарын бүртгэл нь баримт бичгийн тусгай төрөл бөгөөд тэдгээрийг 4.2.4-т заасан шаардлагын дагуу хянана. Дараахь зүйлд шаардагдах хяналтыг тодорхойлсон баримтжуулсан журам бий болгон мөрдөж ажиллаж байна.



Үүнд:

- a) Баримт бичгийг хэвлэхээс өмнө хангалттай эсэх талаас нь хянаж баталж байх
- b) Баримт бичигт дүн шинжилгээ хийж, шаардлагатай бол шинэчилж, дахин баталж байх
- c) Баримт бичгийн өөрчлөлт, хянаж шинэчилсэн төлөв байдлыг тодорхой байлгах
- d) Хэрэгцээт баримт бичгийг хэрэглэх газарт нь зохих хувилбараар нь бэлэн байлгах
- e) Баримт бичгийг гаргацтай тод бөгөөд ялгаж таниж олоход хялбар байлгах
- f) Гадны гаралтай баримт бичгийг бүртгэж тодруулан тэдгээрийн түгээлтийг хяналттай байлгах
- g) Хуучирсан баримт бичгийг санамсаргүй хэрэглэхээс сэргийлж, хэрвээ аливаа нэгэн зорилгоор хадгалж байгаа бол тэдгээрийг сайтар бүртгэн тэмдэгжүүлэх.

Эдгээр шаардлага нь Баримт бичгийн хяналтын журам (СҮАЖ-ОАНДХ-04-2017)-д тодорхой тусгагдсан байна.

Чанарын бүртгэлийн хяналт

Нийгмийн даатгалын байгууллагын чанарын удирдлагын тогтолцоо нь стандартын шаардлагад тохирч, үр нөлөөтэй хэрэгжиж байгаагийн баталгаа болгохын тулд бүртгэлийг бий болгон хадгална.

Чанарын бүртгэл нь гаргацтай тод бөгөөд ялган таних, олж авахад хялбар байвал зохино.

Ялган таних, хадгалах, хамгаалах, олж авах, хадгалах хугацаа болон устгахад шаардагдах хяналтыг Бүртгэл хяналтын журмын дагуу хэрэгжүүлнэ.

7.5.2. Мэдээлэл бий болгох, шинэчлэх

Баримтжуулсан мэдээллийг бий болгож шинэчлэхдээ дараах зүйлийг тодорхой болгоно. Үүнд:

а/ тэмдэглэгээ ба тайлбар /нэр, огноо, зохиогч, дугаар гэх мэт/

б/ хэлбэр /хэл, программ хангамжийн хувилбар, график гэх мэт/ ба зөөгч /цаас, цахим мэдээлэл гэх мэт/

в/ тохиромжтой болон зохистой байдалд дүн шинжилгээ хийх, баталгаажуулах/



7.5.3. Баримтжуулсан мэдээллийг хянах

7.5.3.1. Чанарын удирдлагын тогтолцоонд шаардагдах баримт бичгүүд нь хяналттай байвал зохино. Чанарын бүртгэл нь баримт бичгийн тусгай төрөл бөгөөд тэдгээрийг 7.5.3.2–т заасан шаардлагын дагуу хянана.

Дараахь зүйлд шаардагдах хяналтыг тодорхойлсон баримтжуулсан журам бий болгон мөрдөж ажиллаж байна. Үүнд:

- a) Баримт бичгийг хэвлэхээс өмнө хангалттай эсэх талаас нь хянаж баталж байх
- b) Баримт бичигт дүн шинжилгээ хийж, шаардлагатай бол шинэчилж, дахин баталж байх
- c) Баримт бичгийн өөрчлөлт, хянаж шинэчилсэн төлөв байдлыг тодорхой байлгах
- d) Хэрэгцээт баримт бичгийг хэрэглэх газарт нь зохих хувилбараар нь бэлэн байлгах
- e) Баримт бичгийг гаргацтай тод бөгөөд ялгаж таниж олоход хялбар байлгах
- f) Гадны гаралтай баримт бичгийг бүртгэж тодруулан тэдгээрийн түгээлтийг хяналттай байлгах
- g) Хуучирсан баримт бичгийг санамсаргүй хэрэглэхээс сэргийлж, хэрвээ аливаа нэгэн зорилгоор хадгалж байгаа бол тэдгээрийг сайтар бүртгэн тэмдэгжүүлэх.

Эдгээр шаардлага нь Баримт бичгийн хяналтын журам (СҮАЖ-ОАНДХ-04-2017-д тодорхой тусгагдсан байна.

7.5.3.2. Чанарын бүртгэлийн хяналт

Нийгмийн даатгалын байгууллагын чанарын удирдлагын тогтолцоо нь стандартын шаардлагад тохирч, үр нөлөөтэй хэрэгжиж байгаагийн баталгаа болгохын тулд бүртгэлийг бий болгон хадгална.

Чанарын бүртгэл нь гаргацтай тод бөгөөд ялган таних, олж авахад хялбар байвал зохино.

Ялган таних, хадгалах, хамгаалах, олж авах, хадгалах хугацаа болон устгахад шаардагдах хяналтыг Бүртгэлийн дагуу хэрэгжүүлнэ.

8. Ажиллагаа

8.1. Ажиллагааны төлөвлөлт ба хяналт

Нийгмийн даатгалын байгууллага нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төсвийн төсөөллийг жил бүр боловсруулж нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд хэлэцүүлж



төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлж батлуулан ажилладаг. Энэхүү төсвийн хүрээнд дараахь төрлийн даатгалын үйлчилгээг иргэд даатгуулагчид хүргэж ажиллаж байна.

Үүнд:


- Тэтгэврийн даатгал
- Тэтгэмжийн даатгал
- Ажилгүйдлийн даатгал
- ҮОМШӨ-ний даатгал
- Эрүүл мэндийн даатгал

8.2. Үйлчилгээний шаардлага, арга зүй, стандарт

Иргэд даатгуулагчид хүргэх даатгалын үйлчилгээ чанартай, хөнгөн шуурхай байлгах шаардлагуудыг чанарын зорилтод агуулан тодорхойлж хүлээгдэж буй үр дүн, гүйцэтгэлийн түвшинг тодорхойлж төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.

Даатгалын үйлчилгээг өндөр түвшинд хүргэхийн тулд олон улсын тэргүүн туршлагаас тасралтгүй суралцаж ажилладаг.

Нийгмийн даатгалын тогтолцоо





8.2.1. Хэрэглэгчтэй холбоо тогтоох

Нийгмийн даатгалын хэрэглэгч гэж:

I.Аж ахуйн нэгж, байгууллага:

- Гэрээ байгуулан хамтран ажиллаж буй аж ахуйн нэгж, байгууллага:

- Банкны байгууллага
- Эмнэлгийн байгууллага
- Рашаан сувилал
- Эмийн сан
- Телевиз
- Сонин хэвлэл
- Олон улсын байгууллага
- Мэргэжлийн өвчин судалалын төв
- Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв
- Хамтын ажиллагаа-түншлэл
- Төрийн байгууллага
- Олон улсын байгууллагууд
- Холбоо
- Хувийн хэвшил
- Их дээд сургууль

- Мэдээллийн технологийн програм хангамжийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллагууд

- Мэдээллийн технологи, шуудан харилцаа холбооны газар
- Харилцаа холбооны зохицуулах хороо
- Телевиз
- Радио
- Сайт

II.Даатгуулагч (иргэд):

- Тэтгэвэр авагч
- Тэтгэмж авагч
- Сайн дурын даатгуулагч
- Малчин
- Хувиараа хөдөлмөр эрхлэгч
- Бичил уурхай эрхлэгч
- Газар тариалан эрхлэгч

8.2.2. Нийгмийн даатгалын үйлчилгээнд хамаарах шаардлагыг тодорхойлох

Нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэхдээ “Нийгмийн даатгалын



тухай хууль”, тэдгээрт хамаарах бусад дүрэм, журам, зааврын хэрэгжүүлэн ажилладаг ба хяналтыг байнга хийж ажилладаг. Эдгээрт хамаарах процессуудын явц, гүйцэтгэлийг хэрэгжүүлэх стандарт үйл ажиллагааны журам, ажлын заавар, гүйцэтгэлийн хэмжүүрүүдийг тодорхойлж баримтжуулан мөрдөн ажилладаг.

а/ Ингэхдээ бид үйлчилгээндээ доорх шаардлагыг тавьж байна.

Үүнд:

1.“Нийгмийн даатгалын тухай хууль”, “Төрийн албаны тухай хууль” болон салбарын бусад хууль тогтоомжууд, түүгээр тогтоосон аливаа шаардлагыг хангана.

2. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын /хуучин нэрээр/ даргын 2016 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/61 дүгээр тушаалыг үндэслэн хэлтсийн даргын 2017 оны 2017 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн Б/17 дугаар тушаалаар баталсан “Ажлын байрны стандарт”-ын шаардлагыг хангаж ажиллана.

б/ байгууллагаас үзүүлж буй нийгмийн даатгалын үйлчилгээний талаар ажил олгогч, иргэд, даатгуулагчдаас гаргаж байгаа санал гомдлыг шийдвэрлэхдээ:

“Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль” болон салбарын хэмжээнд мөрдөж байгаа журмын хүрээнд шийдвэрлэнэ. Иргэдийн сэтгэл ханамжийн түвшинг “Нийгмийн даатгалын газрын үйлчилгээний сэтгэл ханамжийн судалгаа авах журам”-ыг баримтлан тогтоож, хяналт тавина. /СҮАЖ-ОАНДХ-03-2017/

8.2.3. Нийгмийн даатгалын үйлчилгээнд хамаарах шаардлагад дүн шинжилгээ хийх

Нийгмийн даатгалын байгууллагын удирдлага нь чанарын бодлого, зорилтуудын биелэлт болон ЧУТ-ны процессуудын хэрэгжилтийн үр дүн, үр нөлөөнд хагас жил тутамд удирдлагын дүн шинжилгээ хийж, иргэд, даатгуулагчдын шаардлагыг хангаж байгаа эсэх болон стандарт үйл ажиллагааны журам, ажлын заавруудыг мөрдөж байгаа эсэхийг нягтлан үздэг.

Дүн шинжилгээний зорилго нь ЧУТ-ны тохиромжтой, үр дүнтэй байдал ямар түвшинд хэрэгжиж байгааг тогтоож, цаашид сайжруулалтыг хийхэд шаардагдах нөөц, ямар арга хэмжээ авч ажиллах талаарх шийдвэрийг гаргаж ажилладаг.



Дүн шинжилгээний орц

Удирдлагын дүн шинжилгээний хурлаар ЧУТ-нд хамаарах дараахь бүхий л асуудлуудыг хэлэлцдэг. Үүнд:

а.Өмнөх удирдлагын дүн шинжилгээний хурлын шийдвэрийн биелэлт

b.Чанарын дотоод, гадаад аудитын үр дүн

c.Чанарын бодлого, зорилтуудын биелэлт

d.Даатгуулагчдын санал хүсэлт, гомдол

e.Процесийн гүйцэтгэл, бүтээгдэхүүн, үйлчилгээний стандартын биелэлт

f.Тохирол, үл тохирлын мэдээлэл

g.Урьдчилан сэргийлэх, залруулах үйл ажиллагааны явц, үр дүн

h.ЧУТ-ны өөрчлөлтүүд

i.Сайжруулалтуудын зөвлөмжүүд

Дүн шинжилгээний гарц

Удирдлагын дүн шинжилгээний хурлаар дараахь чиглэлүүдээр шийдвэр гаргадаг.

a.ЧУТ-ны үр нөлөөний сайжруулалт

b.Процесийн сайжруулалт

c.Даатгуулагчийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн бүтээгдэхүүн, үйлчилгээний сайжруулалт

d.Нөөцийн хэрэгцээ, хангалт

8.2.4. Нийгмийн даатгалын шаардлагад орсон өөрчлөлт

Нийгмийн даатгалын газар нь үйлчилгээний шаардлага өөрчлөгдсөн бол баримтжуулсан Мэдээллийг өөрчилж, холбогдох ажилтныг энэ тухай мэдээллийг өөрчилж, холбогдох ажилтныг энэ тухай мэдээллээр хангана.

8.3. Бүтээгдэхүүн, үйлчилгээний дизайн ба боловсруулалт хийх

8.3.1. Ерөнхий зүйл

Нийгмийн даатгалын газар нь нийгмийн даатгалын үйлчилгээг иргэд олон нийтэд хүргэн, үйлчилгээг хангахад тохирсон дизайн ба боловсруулалт хийнэ. Үүнд:

- Байгууллагын билэгдэл

- Байгууллагын туг далбаа

- Дүрэмт хувцас



- Хаяг, мэдээллийн самбарын дизайн
- Нийгмийн даатгалын байцаагч /ажилтан/-ийн нэрийн хуудас
- Одон медаль, энгэрийн тэмдэг

8.3.2. Дизайн ба боловсруулалтын төлөвлөлт

Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын 2013 оны тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын байгууллагын бэлгэдэл, сурталчилгааны бүтээгдэхүүний жишиг загвар”-ыг дагаж мөрдөнө. / жишиг загварыг энэхүү гарын авлагын хавсралт-1-д тусгав/

Мөн аймгийн Нийгмийн даатгалын газар нь байгууллагын даргын тушаалаар баталсан “Ажлын байрны стандарт”-ыг дагаж мөрдөн ажиллах бөгөөд энэхүү стандартыг Нийгмийн даатгалын газрын даргын тушаалаар батална. Уг стандартад дизайны оролт, гаралт, үйлчлэх цар хүрээг тусгасан байна. /СҮАЖ-ОАНДХ-07-2017/

8.3.3. Дизайн ба боловсруулалт хийх үйл явцын оролтууд

Орхон аймгийн Нийгмийн даатгалын газар нь иргэд, даатгуулагчдад үзүүлж буй үйлчилгээндээ үйлчилгээний стандартыг баримталж ажиллах бөгөөд албан хаагчид байцаагч нар дүрэмт хувцас өмсөж үйлчилгээ үзүүлнэ. Мөн байгууллагын хаяг, өрөө тасалгаанд байгууллагын билэгдлийг байршуулж, туг далбаатай байна. Эдгээр дизайн шаардсан орцын стандартыг Нийгмийн даатгалын ерөнхий газраас нэг мөр дагаж мөрдөхөөр баталгаажуулсныг мөрдөнө.

Дизайн ба боловсруулалт хийх үйл явцын оролт нь хангалттай, иж бүрэн, давхардалгүй байхаас гадна Нийгмийн даатгалын Ерөнхий газраас баталсан стандартаас зөрүүтэй байж болохгүй.

8.3.4. Дизайн ба боловсруулалт хийх үйл явцын хяналт

Аймгийн Нийгмийн даатгалын газар нь:

а/ хүрэх гэж буй үр дүнг тогтоох

б/ дизайн ба боловсруулалт хийх үйл явцын үр дүн шаардлага хангах чадвартайг үнэлэх зорилгоор дүн шинжилгээ хийх,

в/ дизайн ба боловсруулалт хийх үйл явц ба аймгийн Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2017 оны А/173 дугаар тушаалаар баталсан “Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн ажлын байрны стандарт”-тай тохирч байгаа эсэхийг шалгаж баталгаажуулна.

г/ эцсийн үйлчилгээний зориулалтын болон тодорхой хэрэглээний шаардлагыг хангаж байгааг тодорхойлохын тул баталгаажуулалтын үйл ажиллагаа явуулсныг



д/ хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, хянаж шалгах, баталгаажуулах явцад гарсан шаардлагатай аливаа асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авсан байхыг,

Эдгээр арга хэмжээний талаарх баримтжуулсан мэдээллийг хөтөлж хадгалах нөхцлийг тус тус хангахуйц дизайн ба боловсруулалт хийх үйл явцуудыг хянана.

8.3.5. Дизайн ба боловсруулалт хийх үйл явцын гаралт

Аймгийн Нийгмийн даатгалын газар нь:

а/ Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар баталсан дизайн бүхий форм, билэгдэл, туг далбаа, холбогдох стандартыг хэрэглэх бөгөөд зарим шаардлагатай стандартыг тэдгээрт нийцүүлэн баталж шаардлагад нийцүүлэх.

б/ Нийгмийн даатгалын дагалдах үйлчилгээний дагалдах үйлчилгээнд тохирсон байх.

в/ Мониторинг ба хэмжилтийн тохиромжтой шаардлага болон хүлээж авах шалгуурыг тусгах буюу иш татах ба Нийгмийн даатгалын ерөнхий газар болон аймгийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн даргын тушаалаар баталсан дизайн боловсруулалтыг хэрэглэнэ.

г/ Үйлчилгээний зориулалтад нийцсэн, зөв, аюулгүй байдалд чухал үзүүлэлтийг тогтоох зориулалттай дизайн ба боловсруулалт хийх үйл явцын гаралтууд байх нөхцлийг тус тус хангана.

8.3.6. Дизайн боловсруулалт хийх үйл явцын өөрчлөлт

Нийгмийн даатгалын газар нь үйлчилгээний шаардлагын тохиролд сөрөг нөлөөгүй байдлыг хангах хэр хэмжээнд, дизайн ба боловсруулалт хийх явцад эсвэл дараа нь гарсан өөрчлөлтийг тогтоож, дүн шинжилгээ хийж, хянана.

Дараах баримтжуулсан мэдээллийг хөтөлж, хадгална.

а/ дизайн ба боловсруулалт хийх үйл явцын өөрчлөлт

б/ дүн шинжилгээний үр дүн

в/ өөрчлөлт хийх зөвшөөрөл

г/ сөрөг нөлөөллөөс сэргийлэх арга хэмжээ

8.4. Гаднаас нийлүүлж буй үйл явц, бүтээгдэхүүн, үйлчилгээний хяналт

8.4.1. Ерөнхий зүйл

Нийгмийн даатгалын байгууллагад бараа материал, техник хэрэгсэл, үйлчилгээг худалдан авахдаа “Төрийн болон орон нутгийн



өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” Монгол улсын хуулийг мөрдөж ажилладаг.

Нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэхдээ “Нийгмийн даатгалын тухай хууль”, тэдгээрт хамаарах бусад дүрэм, журам, зааврын хэрэгжүүлэн ажилладаг ба хяналтыг байнга хийж ажилладаг. Эдгээрт хамаарах процессуудын явц, гүйцэтгэлийг хэрэгжүүлэх стандарт үйл ажиллагааны журам, ажлын заавар, гүйцэтгэлийн хэмжүүрүүдийг тодорхойлж баримтжуулан мөрдөн ажилладаг.

8.4.2. Хяналт төрөл ба хэр хэмжээ

Байгууллагын гаднаас нийлүүлж байгаа үйл явц, бүтээгдэхүүн, үйлчилгээ нь манай байгууллагын үйлчилгээг иргэд, даатгуулагчдад тогтвортой хүргэх чадварт сөрөг нөлөө үзүүлэхгүй байх нөхцлийг хангана.

Аймгийн Нийгмийн даатгалын газар нь:

а/ гаднаас нийлүүлж байгаа үйл явцууд нь байгууллагын чанарын менежментийн тогтолцооны хяналтад байлгах,

б/ гадны нийлүүлэгч болон түүний гаргаж байгаа гаралтын аль алинд нь зориулсан хяналтыг тогтоох,

в/ дараах асуудлыг авч үзэх:

1/ нийгмийн даатгалын үйлчилгээний хэрэглэгчийн болон хуулийн зохицуулалтын шаардлагыг тууштай хангах талаарх байгууллагын чадварт гаднаас нийлүүлж байгаа үйл явцад үзүүлэх боломжит нөлөөлөл

2/ гадны хэрэглэгчийн хэрэглэж байгаа хяналтын үр нөлөөтэй байдал

г/ гаднаас нийлүүлж буй үйл явц, бүтээгдэхүүн, үйлчилгээ нь шаардлага хангаж байгаа нотлох шалгалт буюу бусад үйл ажиллагааг тодорхойлох асуудлуудыг тус тус шийдвэрлэнэ.

8.4.3. Гадны нийлүүлэгчдэд зориулсан мэдээлэл

Нийгмийн даатгалын газар нь гадны нийлүүлэгчидтэй холбоо харилцаа тогтоохоо өмнө тавих гэж байгаа шаардлага тохиромжтой байх нөхцлийг хангана.

Газар нь:

а/ Нийлүүлэх гэж байгаа үйл явц, үйлчилгээний талаарх

б/ Мөн

1/ нийгмийн даатгалын цогц үйлчилгээ

2/ арга, үйл явц, тоног төхөөрөмж



З/ тогтвортой, байнгын үйлчилгээ үзүүлэхийг баталж байна.

в/ Аймгийн Нийгмийн даатгалын газрын нийт байцаагч нарын 100 хувь нь дээд боловсролтой. Үүнээс: нь магистр зэрэгтэй.

19 буюу 52.7 хувь нь эдийн засагч,

5 буюу 13.8 хувь нь нягтлан бодогч

2 буюу 5.5 хувь нь хууль, эрхзүйч мэргэжилтэй байна.

Үүнээс 20 гаруй төрийн албан хаагч нийгмийн даатгалын мэргэжлээр мэргэшсэн албан хаагчид байна.

г/ Нийгмийн даатгалын газар нь аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллагууд, аж ахуйн нэгжүүдийн удирдлага, санхүүгийн алба, нягтлан бодогчид, даатгуулагчид, иргэдтэй байнга харицаж ажилладаг.

д/ Нийлүүлэх үйлчилгээ:

Нийгмийн даатгалын байгууллага нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төсвийн төсөөлөлийг жил бүр боловсруулж нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд хэлэцүүлж төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлж батлуулан ажилладаг. Энэхүү төсвийн хүрээнд дараахь төрлийн даатгалын үйлчилгээг иргэд даатгуулагчид хүргэж ажиллаж байна. Үүнд:

- Тэтгэврийн даатгал
- Тэтгэмжийн даатгал
- Ажилгүйдлийн даатгал
- YOMШӨ-ний даатгал

е/ гадны нийлүүлэгчийн байранд хэлтсээс эсвэл тэдний хэрэглэгчдийн зүгээс хийх шалгалт буюу баталгаажуулалтын үйл ажиллагаанд хамаарах шаардлагыг гадны нийлүүлэгчдэд тус тус мэдээлнэ.

8.5. Үйлдвэрлэл явуулах ба үйлчилгээ үзүүлэх.

8.5.1. Үйлдвэрлэл явуулах ба үйлчилгээ үзүүлэх ажлын хяналт

Нийгмийн даатгалын газар нь үйлчилгээг хяналттай нөхцөлд гүйцэтгэнэ.

Холбогдох стандарт үйл ажиллагааны болон чанарын хяналтын журмууд, ажлын зааврууд, холбоотой хуулийн заалтуудыг ашиглан нийгмийн даатгалын байгууллагын үндсэн процессийн явцад хяналт тавьж ажилладаг.

Процессийн хяналт, хэмжилтийг хийхдээ процесс бүрт тохирох арга хэрэгслийг ашиглан ямар нэгэн хэлбэлзэл байвал холбогдох газар Нийгмийн даатгалын газрын удирдлагуудад мэдэгдэнэ. Удирдлагууд



нь тухайн нөхцөл байдлаас хамааран залруулах болон урьдчилан сэргийлэх тохиромжтой арга хэмжээг авч ажиллана.

Даатгалын үйлчилгээг иргэд, даатгуулагчийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэхийн тулд байнга хяналт тавьж ажилладаг. Үүний тулд үйлчилгээний стандарт боловсруулж мөрдөн, хяналт тавьж ажиллаж байна.

8.5.2. Тэмдэглэгээ ба мөшгөх боломж

Аймгийн нийгмийн даатгалын тэмдэглэгээ ба мөшгих боломжийг Эрүүл мэнд, нийгмийн даатгалын Ерөнхий газрын /хуучин нэрээр/ даргын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/194 дүгээр тушаалаар баталсан “Анхан шатны маягт, эмхтгэл болон сурталчилгааны товхимолын захиалга авах, хэвлүүлэх, хүлээлгэн өгөх, хадгалах, бүртгэх, тэдгээрийн зарцуулалтад хяналт тавих журам”-аар зохицуулж, дагаж мөрдөнө. Иш таталт-ЖРМ-НДЕГ-а/194-2017

Энэхүү журмын зорилго нь Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд ашиглагдах анхан шатны маягт, эмхтгэл болон сурталчилгааны товхимол /индекс, код, хувийн дугаар, улсын байцаагчийн тамга, тэмдэг, түүний дугаар бүхий баримт бичгүүд/-ын захиалга авах, хэвлүүлэх, төв, орон нутгийн Нийгмийн даатгалын байгууллагуудад хүргүүлэх, хадгалах, бүртгэх, тэдгээрийн зарцуулалтад хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулна.

Тэмдэглэгээ буюу үнэт цаасны индекс, код, дугаарыг тус Нийгмийн даатгалын газрын үнэт цаасны нярав /эд хариуцагч/ байцаагч нарт өмнөх олгосон материалын тооцоог хийсний дараа материалыг олгож, байцаагчийн нэр, материалын төрөл бүрээр бүртгэл хөтөлнө.

-Нийгмийн даатгалын газрын үнэт цаасны нярав байцаагч нартай материалын тооцоог сар бүр хийнэ.

-Материалын тооцоо хийгээгүй болон тооцооны зөрүүтэй байцаагчид материал нэмж олгохгүй

-Няравын материалын зарцуулалтад үйл ажиллагааны нягтлан бодогч хяналт тавьж, сар бүр тайлан гаргуулан тооцоог бодно.

-Нийгмийн даатгалын газар улирал бүр Нийгмийн даатгалын ерөнхий газартай материалын тооцоо нийлж, баталгаажуулна.

-Нийгмийн даатгалын төв байгууллагаас бичгээр өгсөн зөвшөөрөлтэйгээс бусад тохиолдолд материалыг бусдад шилжүүлэх, зориулалт бусаар ашиглахыг хориглоно.



-Хэрэглэх хугацаа дууссан шаардлага хангахгүй болсон, гэмтсэн материалыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын зөвшөөрлийн дагуу хүчингүй болгон устгаж, акт үйлдэнэ.

Мөн Нийгмийн даатгалын Ерөнхий газрын 2010 оны 163 дугаар тушаалаар баталсан “тэтгэвэр, тэтгэмж тогтооход шаардагдах баримт бичгийг бүрдүүлэх, хянах журам”, “Тэтгэвэр тогтоолгох иргэний бүртгэл”, НДМаягт №1, “Зөвлөмжийн хуудас” НДМаягт№2-ыг тус тус дагаж мөрдөнө. НДЕГ-УАЖ-163-2010

8.5.3. Хэрэглэгч болон гадны нийлүүлэгчийн өмч

Хэрэглэгчийн өмч гэж:

- Аж ахуйн нэгж байгууллага;
- Улсын бүртгэлд бүртгүүлсэн гэрчилгээний хуулбар,
- “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан (Маягт НД-7)”,
- “.....ажиллаж буй даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл ногдуулалт (Маягт НД-8)” тайлан, (цаасаар болон цахимаар),
- Санхүүгийн тайлан,
- Тендерийн материал,
- Цагдаа, хүчний байгууллагын тодорхойлолт.

- Даатгуулагч (иргэд):

- Тэтгэвэр, тэтгэмж авахад бүрдүүлж өгсөн анхан шатны баримт:
- Нийгмийн даатгалын дэвтэр,
- Хөдөлмөрийн дэвтэр,
- Эрүүл мэндийн гэрчилгээ,
- Гэрлэлтийн баталгаа,
- Төрсний гэрчилгээ
- Албан байгууллагын тушаал, шийдвэр,
- Цалингийн тодорхойлолт.
- Хувийн хэрэг, түүний доторх мэдээлэл:
- Албан тушаал,
- Гар утасны дугаар,
- email хаяг

Хэрэглэгчийн өмчийг хамгаалах арга хэрэгсэл гэж:

- Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны төрийн нарийн бичгийн даргын 2009 оны 143 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Мэдээллийн технологийн аюулгүй байдлын бодлого”,
- Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 31 дүгээр тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын байгууллагаас иргэн (хуулийн этгээд)-д мэдээлэл, лавлагаа олгох журам”,



-Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2016 оны 05 дугаар тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын байгууллагуудад ашиглагдах хэрэглэгчийн болон сервер компьютерийн ашиглалт, тэдгээрт хандах хэрэглэгчийн эрх, нууцлал хамгаалал, аюулгүй байдлын журам”-аар зохицуулагдана. /ЖРМ-НДБХГ-01-2015/

8.5.4. Бүтээгдэхүүн үйлчилгээг хамгаалах

Нийгмийн даатгалын байгууллагын чанарын удирдлагын тогтолцоо нь стандартын шаардлагад тохирч, үр нөлөөтэй хэрэгжиж байгаагийн баталгаа болгохын тулд бүртгэлийг бий болгон хадгална. Чанарын бүртгэл нь гаргацтай тод бөгөөд ялган таних, олж авахад хялбар байвал зохино. Ялган таних, хадгалах, хамгаалах, олж авах, хадгалах хугацаа болон устгахад шаардагдах хяналтыг Бүртгэл хяналтын журам (ЧХЖ–ТГ–02–2015)-ын дагуу хэрэгжүүлнэ.

8.5.5. Нийлүүлэлтийн дараах үйл ажиллагаа

Нийгмийн даатгалын газар нь үйлчилгээнд хамаарах нийлүүлэлтийн дараах шаардлагыг хангана. Нийлүүлэлтийн дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээг тодорхойлохын тулд доорх зүйлийг авч үзнэ. Үүнд:

- а/ Холбогдох хуулийн болон зохицуулалтын шаардлага,
- б/ үйлчилгээнд хамаарах боломжит тааламжгүй үр дагаврууд
- в/ үйлчилгээний мөн чанар, хэрэглээ ба ашиглалтын хугацаа
- г/ хэрэглэгчийн шаардлага
- д/ хэрэглэгчийн санал хүсэлт

8.5.6. Өөрчлөлтийн хяналт

Нийгмийн даатгалын газар нь үйлчилгээ үзүүлэх явц дахь өөрчлөлтүүд нь шаардлагад тохиролтой хэвээр байгааг бататгах хяналт, дүн шинжилгээг хэрэгжүүлнэ. Эдгээр өөрчлөлтөд хийсэн дүн шинжилгээний үр дүнд өөрчлөлт хийх эрх бүхий ажилтны мэдээлэл, дүн шинжилгээний дагуу авсан арга хэмжээнүүдийн талаарх баримтжуулсан мэдээллийг хөтөлж хадгална.

8.6. Бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргаж бэлтгэх

Нийгмийн даатгалын газар нь эрүүл мэнд, нийгмийн даатгалын үйлчилгээ нь шаардлага хангаж байгааг шалгах төлөвлөгөөт арга хэмжээнүүдийг холбогдох үе шатанд хэрэгжүүлнэ. Төлөвлөсөн арга хэмжээ хангалттай хэрэгжиж дуусах, холбогдох эрх бүхий байгууллага болон ашиглаж болохыг хэрэглэгч буюу



даатгуулагч зөвшөөрөх хүртэл шинэ үйлчилгээг хэрэглэгчид гаргаж бэлтгэхгүй байна.

Нийгмийн даатгалын газар нь эрүүл мэнд, нийгмийн даатгалын шинэ үйлчилгээг гаргаж бэлтгэхэд хамаарах баримтжуулсан мэдээллийг хөтөлж хадгална. Баримтжуулсан мэдээлэлд:

а/ хүлээн авах шалгуурыг хангаж байгаа тухай нотолгоо

б/ нийгмийн даатгалын үйлчилгээг нийгэмд гаргах эрх мэдэл бүхий албан тушаалтны тодорхойлолт, эрхзүйн акт тус тус багтана.

8.7. Үл тохирол бүхий гаралтын хяналт

8.7.1. Тасгууд процессуудын хэрэгжилтийн явцад болон гүйцэтгэлд гарсан үл тохирлыг илрүүлэх, тэдгээрийг аль болох илэрсэн даруйд засч, залруулах, процессийн шаардлагууд болон шалгууруудыг хангадаагүйн улмаас үүсэх “Үл тохиролд хяналт” тавьж ажиллаж байна.

Нийгмийн даатгалын газар нь үл тохирлоо илэрсэн болон болзошгүй үл тохирол гэж ангилан авч үзээд залруулах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллаж байна.

ЧУТ-ны баримт бичиг болон процессийн хэрэгжилт, үйлчилгээнд дараах шаардлагуудыг авч үзэн хяналт тавьж ажиллаж байна. Үүнд:

- Хэрэглэгчээс тогтоосон шаардлага
- Бүх процессийн хэрэгжилт, хяналтын шаардлага
- Үйлчилгээний стандарт
- Үйлчилгээнд хамаарах хууль тогтоомж, өөрчлөлтийн хяналт

шаардлага

- Байгууллагаас тогтоосон шаардлага

Үл тохирол нь дараахь эх үүсвэрүүдээс илэрч болно гэж журамд дурьдан оруулсан байгаа. Үүнд:

- Иргэд даатгуулагч, ажил олгогч даатгуулагч гомдол, санал
- Процессийн хэрэгжилтийн тоон мэдээлэл, чиг хандлага
- Процессын эзэн хариуцагч буюу процесст оролцогч
- Төр, засаг, хууль эрх зүйн байгууллага
- Чанарын дотоод, гадаад аудит
- Удирдлагын хяналт
- Бусад

Чанарын удирдлагын тогтолцооны шаардлагуудын үл тохирлын хяналт, түүний мөрөөр авах арга хэмжээ, сайжруулалтыг хэрэгжүүлж, үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэсэн Үл тохирлын журам боловсруулан мөрдөж ажиллаж байна.



8.7.2. Дараах баримтжуулсан мэдээллийг хөтөлж хадгална. Үүнд:

- а/ үл тохирлын тухай тайлбар,
- б/ авсан арга хэмжээний тухай тайлбар,
- в/ тохиролцсон тухай тайлбар,
- г/ үл тохирлын талаар шийдвэр гаргах эрх мэдлийг

тодорхойлох.

9. Гүйцэтгэлийн үнэлгээ

9.1. Мониторинг, хэмжилт, шинжилгээ ба үнэлгээ

9.1.1. Ерөнхий зүйл

Нийгмийн даатгалын газар нь:

а/ иргэд, даатгуулагчдын шаардлагыг магадлах, хэмжих,

б/ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, аймгийн Засаг даргын 2017 оны 10 дугаар сарын 24-ны өдрийн А/621 дүгээр захирамжаар батлагдсан “Аймгийн хэмжээнд мөрдөх орон нутгийн захиргааны байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ын аргуудыг хэрэглэнэ.

в/ Мониторинг, хэмжилтийг хагас, бүтэн жилээр гүйцэтгэнэ. Шаардлагатай бол тухай бүр

г/ Мониторинг, хэмжилтийн үр дүнд дахин хэдийд шинжилгээ, үнэлгээ хийхийг тус тус тодорхойлно.

Нийгмийн даатгалын газар нь чанарын менежментийн тогтолцооны гүйцэтгэл болон үр нөлөөг үнэлнэ. Нийгмийн даатгалын газар нь үнэлгээний үр дүнд холбогдох баримтжуулсан мэдээллийг нотолгоо болгон хөтөлж хадгална.

9.1.2. Хэрэглэгчийн сэтгэл ханамж

Бид цаг үргэлж даатгуулагч иргэн, ажил олгогч даатгуулагчийн шаардлагад нийцүүлэхэд гол анхаарлаа төвлөрүүлж ажилладаг. Тэдгээрийн сэтгэл ханамжийг хэмжихийн тулд жилд 1-2 удаа өөрсдийн хүчээр судалгаа хийн дүн шинжилгээ хийн ажиллаж байна. Нийгмийн даатгалын байгууллага нь иргэд, даатгуулагчийн санал, хүсэлт, талархал, гомдлыг боломжит бүх төрлийн сувгаар хүлээж авдаг бөгөөд тэдгээрийг шийдвэрлэлтийг СҮАЖ-ОАНДХ-02-2017 журмын дагуу зохион байгуулдаг.

Энэхүү стандарт үйл ажиллагааны журамд нийгмийн даатгалын байгууллагын хэмжээнд иргэд, даатгуулагчийн санал хүсэлт, гомдол хүлээн авч баримтжуулан, барагдуулах, тайлан мэдээ гаргах, дүн шинжилгээ хийх процессийг тодорхой болгох, үүний үндсэн дээр



иргэд, даатгуулагчийн сэтгэл ханамжийн түвшин болон бүтээгдэхүүн үйлчилгээний талаархи тэдний эрэлт хэрэгцээг тодорхойлох, эдгээр үйл ажиллагаанд оролцогч алба хэлтсүүдийн үүрэг хариуцлага ажлын уялдаа холбоог тодорхойлсон байдаг.

9.1.3. Шинжилгээ ба үнэлгээ

Нийгмийн даатгалын байгууллага дараахь зүйлд шаардлагатай ажиглалт, задлан шинжилгээ, сайжруулалтын процессийг төлөвлөн хэрэгжүүлнэ. Үүнд:

а) Үйлчилгээний тохирлын байдлыг харуулах

б) Чанарын удирдлагын тогтолцооны үр нөлөөг байнга сайжруулах

9.2. Дотоод аудит

9.2.1. Нийгмийн даатгалын газрын ЧУТ-ны үр нөлөөг үнэлэх, MNS ISO 9001:2016 стандартын шаардлагуудын нийцлийг шалгах, сайжруулах боломжуудыг илрүүлэхийн тулд Чанарын дотоод аудитыг жилд 2 удаа зохион байгуулахаар төлөвлөдөг.

Аудитаар илэрсэн үл тохирлыг залруулах, давтан гаргахгүй байхын тулд суурь шалтгааныг илрүүлэн арилгаж ажилладаг. Чанарын дотоод аудитын нэгдсэн тайлан гаргаж Удирдлагын дүн шинжилгээний хурал хийж, холбогдох сайжруулалтын шийдвэр зөвлөмжийг гаргаж ажилладаг.

Нийгмийн даатгалын газрын хэмжээнд чанарын дотоод аудитуудыг бэлтгэж, чанарын дотоод аудитыг зохион байгуулахтай холбогдуулан нэр бүхий 41 ажилтныг ажлын туршлага, ур чадвар, ёс зүйн шаардлагуудыг хангах туршлагатай ажилтнуудын тушаалаар томилон ажиллуулж байна. Тэднийг чанарын дотоод аудит хэрхэн явуулах талаар сургалтад хамруулж бэлтгэсэн.

Нийгмийн даатгалын байгууллагын хэмжээнд Чанарын дотоод аудитыг төлөвлөх, удирдан явуулах, үр дүнг тайлагнах, мэдээлэх үйл ажиллагааг хамарсан журам боловсруулагдсан./СҮАЖ-ТГ-03-2015/

9.2.2. Нийгмийн даатгалын газар нь:

а/ холбогдох үйл явцуудын ач холбогдол, байгууллагад нөлөөлж буй өөрчлөлтүүд, өмнөх аудитын үр дүнд үндэслэн аудитын давтамж, аргачлал, хариуцлага, төлөвлөх шаардлага, тайлагнал зэргийг тусгасан аудитын хөтөлбөрийг төлөвлөж, бий болгож, хэрэгжүүлж, мөрдөж ажилладаг.



б/ аудит тус бүрийн шалгуур, хамрах хүрээг тогтооно.

в/ аудитын үйл явц нь бодитой, шударга байхуйцаар аудиторуудыг сонгож, аудит явуулна.

г/ аудитын үр дүнг Нийгмийн даатгалын газрын даргад мэдээлнэ.

д/ зохих залруулга болон залруулах арга хэмжээг хойшлуулалгүй авна.

е/ аудитын хөтөлбөр хэрэгжсэн тухай болон аудитын үр дүнгийн нотолгоо болох баталгаажуулсан мэдээллийг хөтөлж хадгална.

9.3. Удирдлагын дүн шинжилгээ

9.3.1. Ерөнхий зүйл

Нийгмийн даатгалын газрын дарга нь Нийгмийн даатгалын газрын чанарын менежментийн тогтолцоо, стратегийн чиг хандлагад нийцсэн, тохирсон, үр нөлөөтэй, байнга хэрэглэх байдалд нь төлөвлөсөн хугацаанд дүн шинжилгээ тогтмол хийнэ.

9.3.2. Удирдлагын дүн шинжилгээний оролтууд

Удирдлагын дүн шинжилгээг төлөвлөсөн байх ба дараах асуудлуудыг авч үзнэ. Үүнд:

а/ өмнөх удирдлагын дүн шинжилгээний дагуу авсан арга хэмжээний тухай

б/ чанарын менежментийн тогтолцоонд хамаарах гадаад болон дотоод асуудлуудад гарсан өөрчлөлтүүд

в/ чанарын менежментийн тогтолцооны гүйцэтгэл ба үр нөлөөний мэдээлэлд дараах чиглэлийг хамруулна.

1/ холбогдох сонирхогч талуудаас ирсэн санал хүсэлт болон хэрэглэгчийн сэтгэл ханамж,

2/ чанарын зорилтууд биелсэн хэр хэмжээ,

3/ үйл явцын гүйцэтгэл ба үйлчилгээний тохирлын байдал,

4/ үл тохирлууд ба залруулах арга хэмжээнүүд

5/ мониторинг, хэмжилтийн үр дүнгүүд,

6/ аудитын үр дүнгүүд.

7/ гадны нийлүүлэгчдийн гүйцэтгэлийн хандлагыг харуулсан гүйцэтгэлийн хандлагыг харуулсан гүйцэтгэлийн үр нөлөөний тухай мэдээлэл

г/ нөөцийн хангалттай байдал

д/ эрсдэл болон боломжийг авч үзсэн арга хэмжээний үр нөлөө /6.1-ийг үзнэ үү/,

е/ сайжруулах боломжууд



9.3.3. Удирдлагын дүн шинжилгээний гаралтууд

Удирдлагын дүн шинжилгээний гаралтад дараах асуудал бүхий шийдвэрүүд болон арга хэмжээ хамаарна. Үүнд:

а/ сайжруулах боломжууд,

б/ чанарын менежментийн тогтолцоонд оруулах аливаа өөрчлөлтийн хэрэгцээ,

в/ нөөцийн хэрэгцээ,

Нийгмийн даатгалын газар нь удирдлагын дүн шинжилгээний үр дүнг нотлох баримтжуулсан мэдээллийг хөтөлж хадгална.

10. Сайжруулалт

10.1. Ерөнхий зүйл

Нийгмийн даатгалын байгууллага нь чанарын бодлого, чанарын зорилтууд, чанарын дотоод аудитын үр дүн, өгөгдлийн задлан шинжилгээ, залруулах ба урьдчилан сэргийлэх арга хэмжээ, удирдлагын дүн шинжилгээг ашиглах замаар Чанарын удирдлагын тогтолцооны үр нөлөөг байнга сайжруулахыг зорьж ажилладаг.

Энэ зорилтыг биелүүлэхийн тулд

- Удирдлагын дүн шинжилгээний хурал тогтмол зохион байгуулах;

- Процессуудын хэрэгжилт болон явцын мэдээллийн дүн шинжилгээг хийх;

- ЧУТ-ны үр нөлөөг гадны болон дотоод аудитаар үнэлэх;

- Залруулах болон Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

- Чанарын бодлого ба Чанарын зорилтуудын нийцэл болон тохиромжтой байдлыг үнэлэх арга хэмжээг зохион байгуулж байна. Мөн бүтээмж чанарын арга хэрэгслүүд болох 5С, Кайзен, Чанарын дугуйлан зэргийг ажиллуулж, байнгын сайжруулалтыг хийж байна. Байнгын сайжруулалтын бас нэг гол арга хэлбэр нь олон улсын тэргүүн туршлагаас суралцаж хэрэгжүүлдэг.

10.2. Үл тохирол ба залруулах арга хэмжээ

Нийгмийн даатгалын байгууллагын процессуудын хэрэгжилтийн явцад болон үйлчилгээг хүргэсний дараа илэрсэн үл тохирлыг залруулах, дахин гарахаас сэргийлэхийн тулд түүний суурь шалтгааныг арилгах, тухайн процессын үр ашиг, үр нөлөөтэй байдлыг байнга сайжруулах зорилгоор Залруулах үйл ажиллагааны журмыг боловсруулан мөрдөж ажиллаж байна.



Чанарын дотоод аудитууд нь аудит хийх, үл тохирлыг залруулах үүрэг даалгавар өгч, түүний гүйцэтгэлийг баталгаажуулна.

Нийгмийн даатгалын байгууллагын процессуудын явц болон үйлчилгээнд болзошгүй үл тохирол гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журмыг боловсруулан мөрдөж ажиллаж байна. Алба хэлтсүүд урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг батлагдсан журмын дагуу төлөвлөгөөтэй ажиллана. ЧУХ нь урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг авч, УТМС-д бүртгэн холбогдох дүгнэлтийг хийж баримтжуулна гэж журамд тусгасан

10.2.2. Байгууллага баримтжуулсан мэдээллийг:

а/ үл тохирлын мөн чанар, түүний дагуу авсан арга хэмжээнүүд,

б/ аливаа залруулах арга хэмжээний үр дүнг нотлох зорилгоор хөтөлж хадгална.

10.3. Байнгын сайжруулалт

Орхон аймгийн Нийгмийн даатгалын газар нь чанарын менежментийн тогтолцооны зохимж, тохиромж, үр нөлөөг үргэлж сайжруулна.

Нийгмийн даатгалын газар нь байнгын сайжруулалтын хэсэг гэж авч үзэх хэрэгцээ болон боломжуудыг тодорхойлохын тулд дүн шинжилгээ, үнэлгээний үр дүн ба удирдлагын дүн шинжилгээний гаралтыг судлана. Удирдлагын дүн шинжилгээний хурлыг сар бүр хийнэ. Уг хурлаар:

- Сайжруулах боломжууд

- Чанарын менежментийн тогтолцоонд оруулах аливаа өөрчлөлтийн хэрэгцээ,

- Нөөцийн хэрэглээ хамарна.

Нийгмийн даатгалын газар нь сайжруулах боломжуудыг тодорхойлох болон сонгох ба хэрэглэгчийн шаардлагыг хангах, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Дараах арга хэмжээ үүнд хамаарна. Үүнд:

Шаардлагыг хангах ирээдүйн эрэлт хэрэгцээ, найдлагад нийцүүлэхээр үйлчилгээг сайжруулах. Үүнийг хэмжихдээ СҮАЖ-ОАНДХ-02-2017 журмыг баримтлана

Тааламжгүй үр дүнг залруулах, сэргийлэх буюу бууруулахдаа СҮАЖ-ОАНДХ-05-2017 журмыг баримтлана



Чанарын менежментийн тогтолцооны гүйцэтгэл болон үр нөлөөг сайжруулна.

Нийтээр дагаж мөрдөж, хэрэгжилтийг ханган, үр нөлөөг тооцно.

ОРХОН АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ЧАНАРЫН УДИРДЛАГЫН ХОРОО